


АЛТАН-ОЧИРЫН ГОМБОЖАВ



Баруун хил хязгаарын ард иргэдийг паартагчингуудын дээрэмчдийн аюул заналхийлж амар тайван амьдруулахгүй байсан тэр үед Засагт хан аймгийн Ёст бэйсийн хошуу одоогийн Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын цагаан уул багийн нутагт малчин ард Алтан-Очирын гэр бүлд 1927 онд нэгэн хүү мэндэлснийг Гомбосүрэн хэмээх нэр алдар хайрлажээ. Гомбожавын ах Рэгзэн, Базарзагд гэж байсан, дүү нь Содномдоржаа, охин дүү Дашзэвэг нар нь одоо амьд сэрүүн байдаг. А.Гомбожавыг 4-5 настай байсан үед баруун тийшээ Өвөрмонголын нутагт жаргалын орон байна гэсэн цуурхал хошуу нутагт тархсанд үнэмшин Алтан-Очирынх хамаг хадлаг тэжээлээ бэлтгээд малаа туугаад нүүж суух гэж байтал нэг азарга адуу нь олдохгүй болсон тул ах Базарзагд нь хайгаад явсан хойгуур хасгийн дээрэмчид ирээд эрэгтэйчүүдийг нь зодож гэр орныг нь дээрэмдэн үлдсэнийг нь шатаагаад хоттой малыг нь туугаад явжээ.

А.Гомбожав бага насны хүүхэд байсан учраас нохой хуцах чимээтээр дээрэмчдээс хаданд зугтаад гарчихдаг байсан бөгөөд нэг удаад зугтаж чадалгүй баригдсан боловч тоогоогүй орхисон ажээ. Ах Рэгзэн нь 12-13 орчим насны хүүхэд малтайгаа туугдаад явжээ. Хасгууд шөнө нь хэд гурваараа олзны мал, хүмүүсээ буурин манаж хонодог, өдөр нь дээрэмдсэн мал хуйгаа тууж, эд хөрөнгөө ачиж, буулгаад явахдаа зам зууртаа байнгын эсэргүүцэлтэй тулгардаг байжээ. Рэгзэн олон сараар хамт явахдаа итгэлтэй хүний дүр үзүүлж гэр орон нутаг уснаасаа ч их холдсон гэнэ. Нэгэн удаа Хасгийн харуулууд олзны шимийн архи дарсаа ууж наргиж цэнгэж байгаад тасарсан үед Рэгзэн тэр мөчийг

овжиноор ашиглан шөнө дунд болж харуулууд сонор сэрэмжээ алдсаны араар бууг нь авч сайн морьдоо шилж унан азарга адуугаа тасдан хөөгөөд өдөр шөнөгүй давхиж байж нутагтаа ирсэн гэдэг.

А.Гомбожав ч эрийн цээнд хүрч 1947 оны үед Сүхбаатар аймгийн Онгон, Баяндэлгэр суманд цэргийн алба хааж байгаад Ховдын баруун хязгаарт шилжин ирж дайчин нөхөдтэйгөө мөр зэрэгцэн хасгийн дээрэмчдээс эх орон элгэн нутгаа хамгаалж амь хайргүй тэмцэж явсан ахмад хилчин байжээ. Тэрээр нөхдийнхөө хамт автомашины аварт орж цус их алдан ухаан алдан цэргийн эмнэлэгт олон сараар эмчлүүлж байгаад эрүүл мэндийн шалтгаанаар цэргээс халагдсан байдаг.

Эх орон ард түмнийхээ өмнө өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэж байлдааны даалгавраа эр цэргийн ёсоор нэр төртэй биелүүлсэн ахмад хилчин Алтан-Очирын Гомбожавын гэгээн дурсгалыг төрсөн нутаг Эрдэнэ сумын төвд босгосон ахмад дайчдын хөшөөнд нэрийг нь бичиж хойч үед нь мөнхжүүлсэн билээ.

“Цагаан хайрхан эрдэн сан” ТББ-ын тэргүүн Дашнямын Жанчивдорж

АРСЛАНГИЙН ХОГНИН

/Гурван үеийн эх орончид/

Эх орон газар нутаг, хүн ардынхаа төлөө амь биеэ зориулан эр зориг гаргаж баатарлаг гавьяа байгуулсан хүмүүс мөнхрөн үлддэг. Үүний нэгэн жишээ бол тус сумын харьяат Гүржавын Арслан 1911 онд Ардын Хатанбаатар Магсаржавын цэрэгт явж Манжийн амбаны цэргийг Ховд сангийн Хэрэм, баатар хайрхны орчимд байлдан ялалт байгуулсан Монгол цэргийн тугчин байсан бөгөөд Богд хаант Монгол Улсын Засгийн газраас хөх жинст угсаа залгамжлах тайж, тугийн мээрэн цол шагнагдаж байжээ. Түүний хүү Арслангийн Дөрвөлжин 1945 оны чөлөөлөх дайнд холбооны хороонд байлдаж явсан ахмад дайчин аж. Дөрвөлжин аавынхаа дайнд барьж явсан тугийн зэвийг нандигнан хадгалж байгаад хожим Булган аймаг дахь Хатанбаатарын музейд аваачиж хадгалуулжээ.

Мөн удаах хүү Арслангийн Бадарч 1939 оны Халх голын дайнд оролцож 6 дугаар морьт дивизийн 17 дугаар морьт хороонд жагсаалын дарга байсан. Арслангийн ач хүү Тунгалагийн Энхжаргал Баян-Өлгий аймагт 20 гаруй жил Монгол улсынхаа дархан хилийг манаж гавьяа байгуулсан учир “Цэргийн гавьяаны одонгоор шагнагдан дэд хурандаа цолтой гавьяаныхаа амралтад гарчээ. Эх орон тусгаар тогтнолын төлөө нэгэн эцгийн гурван хүүгийн байгуулсан гавьяаг эх орон, ард түмэн, унасан газар шороо нь үл мартаж буйзаа.

Үүний нэгэн адил Арслангийн том хүү Хогнингийн тухай нэгэн сонирхолтой түүхийг хүү Х.Пүрэвдорж, ач хүү П.Нямдаваа нараас ирүүлсэн эх сурвалжтайгаар бичиж байна. А.Хогнин 1910 онд Засагт хан аймгийн Ёст Бэйсийн хошууны нутагт Г.Арслангийн ууган хүү болон мэндэлсэн. Тэр багаасаа аавыгаа дагаж ан гөрөө хийж сурсан, тэсвэр хатуужилтай хүмүүжсэн, ямар ч нөхцөлд амь насаа авраад зогсохгүй овсгоо самбаатай, амьдрах арга ухаанд сургаж байсан нь хожим өөрт нь тун хэрэг болжээ. Хасгийн дээрэмчид Говь-Алтай нурууны өндөрлөг хад асга ихтэй нэгэн хөндий өгсөөд дээрэм тонуул хийхээр ирж байсан долоон хасгийг урьдчилан харж хамгийн боломжтой газар орныг тосон отож байгаад нэгэн том цагаан чулууг давхцуулан дээрэмчдийн толгойлогчийг гарч ирэнгүүт цахиур буугаар нам буудаж унагав. Бусад дээрэмчид нь амиа аван зугтааж тэр нэг удаагийн дээрэм тонуулаас нутгийн иргэдийнхээ амь нас, мал хөрөнгийг хамгаалж чаджээ.

А.Хогнин нь зоригтой, шударга шулуун зантай, хүнд тусархуу нэгэн байсан бөгөөд сумынхаа ан агнуурын төлөвлөгөөт зорилтыг хангахад гол үүрэг гүйцэтгэдэг, хавхтай чоно өөр лүү нь дайрахад овоодож аваад газар мөргүүлэн агнаж байсан удаатай хэлцдэг, улсын анчин хүн байжээ. Хасгийн дээрэмчид өмнөх явдлаас хойш зүрхэнд нь орж / таньдаг паартагчингууд Хогнин чи хаана байна гээд / орилдог байсан гэдэг. Тэд толгойлогчоо буудуулсандаа өширхөж 1932 оны орчим дахин дээрэм хийхээр ирэхдээ нутгийн иргэдээс 2 эмэгтэйг олзлон авч явжээ. А.Хогнин араас нь мөшгөж байгаад 2 буутай хасагтай халз тулсан учир яаж ч чадалгүй хүчин мөхөстөж бүлэг дээрэмчдийн гарт баригдан хамт явах болжээ.

Дээрэмчид хоёр гарыг нь ард нь хүлж хөлийг холбож тэмээнд мордуулан нэг хүн хөтөлж явсан бөгөөд хөлийг холбох үед хоёр хөлөө оймсон дотроо сугалж монгол гутлынхаа гадуур боолгосныг дээрэмчид гадарласангүй өнгөрчээ. Бүтэн өдөржингөө хөлөө ээтийлгэж гутлаа доош сугалахгүй явсан нь бас их арга ухаан тэвчээр шаардаж байлаа. Дээрэмчид Захуй Зармангийн говь Долооны хоолойг гаталж Идрэнгийн нуруунд гарч хоноглохоор явах замд үдшийн бүрий болж гэгээ тасрах үед тэмээг хөтөлсөн хасаг үүрэглэн тонголзож явахыг Хогнин анзаар ч бүтэн өдөржин ээтийлгэж явсан хөлөө сугалан тэмээн дээрээс сэмхэн үсрэн бууж загийн шугуйд нуугдаж хоцорлоо. Хасгууд түүнийг зугтсаныг мэдмэгцээ эрэл хайгуул хийж загийн толгойг шилбүүрдэн цохиж харагдлаа, амиа хамгаалахын тулд арга буюу тэвчээр гарган амьсгаагаа түгжин нуугдаж байлаа.

Тэд шөнө болсон учир эрлээ зогсоож ачаагаа буулгаж хоноглохоор болж заг түлж галаа асаан хоолоо хийн шаагилдаж, тэмээ хөтөлж явсан нэгнийгээ баахан загнаж байгаад хоолоо идэнгээ дээрэмдэн авчирсан хүнснээсээ идэж байв. Хамт яваа нутаг нэгтнээ өрөвдөн харж атаа хорсол төрөвч гартаа барьсан буу зэвсэг байтугай хоёр гараа ардаа хүлүүлсэн, хөл нүцгэн тул тэдэнтэй тэмцэх ямар ч арга байгаагүй тул үүрийн гэгээ орохоос өмнө арга буюу зугтахаас өөр аргагүй байдалд хүрчээ. Шөнөдөө хамаг хүчээ шавхан нутгийн зүг зугтааж холдсон бөгөөд тэр эрчээрээ замдаа зогсохгүйгээр гүйж маргааш оройхон Хөх ус, Баянбулаг орчим хониныхоо бэлчээрт ирж дээрэмчдийн гараас эсэн мэнд мултарснаа мэдэж сэтгэл тайвшран нэгэн чулуу түшин сууж түр амсхийгээд босох гэтэл хамаг бие нь хөдөлж өгөхгүй бүрэн хөшсөн тул яаж ч хичээгээд босож чадаагүй ажээ. Аз болоход нутгийн малчин хонио хариулж яваад түүнийг олж гэрт нь авчирсан гэнээ. Хүү Пүрэвдорж “Хасгууд аавыг минь барьсан даруйдаа толгойлогчоо алуулсан өшөөг авахын тулд нутагтаа амьдаар нь авч очоод тамлаж алхыг хүсдэг байсан байх тэд айлуудын охид, бүсгүйчүүдийг булаан авахаас эрэгтэйчүүдийг авч явдаггүй байсан. Хүн ер нь зорьсон газартаа хүрэхээсээ өмнө сэтгэл амарч тайвширч болдоггүй юм байна лээ” гэж аав минь ярьдаг байсан юм.

Хоёр дахь удаагаа баригдаж, 2 хүний амь аварсан тухай нутгийн иргэн Ш.Нямсүрэнгийн ярьсан эх сурвалжаас: А.Хогнин гуай Ягааны ээж Буурцаг, Зэсрэн, Гүрцоо нарын хамт хасгийн дээрэмчдэд баригдан тэмээний нуруунд хүлүүлэн авч явжээ. Дээрэмчид олсон ашгаа хуваалцан олзлогсдыг гэрт хорьсон байна. А.Хогнин нөгөө гурван хүүхнээ суллан хамт оргох арга сэдэж шөнө дөлөөр өөрийг нь хүлсэн дээсийг жижиг хутгаар огтлон хүлээсээ тайлж 3 хүүхнийг дагуулан зугтах гэсэн боловч Зэсрэн нь уйлж, анхаарал сэрэмжгүй болохоор орхиод нөгөө 2 хүүхнийг дагуулж морь унан зугтаасан гэдэг. Тэд морьтой гурван хоног яваад гэрийнхээ гадаа ирэнгүүт нэг хүүхэн нь мориноосоо үсрэн буухад ээж нь миний хасагт баригдаад явсан хүүхэдтэй яасан адилхан дэвхэрч буудаг хүн бэ гэж байсан чинь баригдаад явсан охин нь мөн байжээ. Тэд ирсэн даруйдаа олон хоног морин дээр явснаас болоод цусаар шээж байсан гэж нутгийн хөгшчүүд хуучилдаг байв. Харин А.Хогнин хөгшний алдар гавьяаг ярихаас өөрөөр дурсан алдаршуулсан удаа байхгүй байхаа. Хогнин гуайг бага байхад цахиур буу үүрээд ан хийхээр явахад аав нь чиний ан хийдэг гэж юу байхав гэж байсан орой нь тэх ганзагалаад ирснийг аав нь харж байснаа сохор тэх ганзагалаад ирж, чиний өмнө амьтай бүхэн сөхрөх учиртай юм байна гэсэн удаатай. Хогнин гуай бас их алиа яриа хөөрөөтэй шог ч хүн байсан 1965 оны орчим санагдана нутгийн хэсэг хүмүүстэй нэгдлийн газ -51 машинаар Баянхонгор аймгийн Шаргалжуутын рашаан орох гэж яваад Эрдэнэ, Чандмань сумын нутгийн зааг дээр “хөх энгэр” хэмээх газарт машин нь онхолдож дөрвөн дугуй нь өөдөө хараад унасан хэдий ч хажуу талын гүүзэв нь төмөр поошог дээр тогтсон байсан тул дээр сууж явсан хүмүүс нь амьд үлджээ. Хогнин гуай “би өнөөдрийн энэ байдалтай нийлээд амьдралдаа гурван удаа амь аврагдлаа” гэсэн гэдэг.

А.Хогнин эхнэр Шоовдортойгоо хамт амьдарч Х.Цэрэнханд, Х.Пүрэвдорж нарын 2 хүүхэдтэй айл байж 1980 он хүртэл нутаг орондоо амар тайван амьдарсан гэнэ билээ.

“Цагаан хайрхан эрдэнэ сан” ТББ -ын тэргүүн Дашнямын Жанчивдорж

БЭГЗИЙН ЦЭНЗЭЭ

Ахмад дайчин Бэгзийн Цэнзээ 1919 онд Засагт хан аймгийн Ёст бэйсийн хошууны нутаг Хутаг уул хэмээх газар төрсөн. Тэрээр 1939 оноос эхлэн Ховд аймгийн



Алтай суман дахь хязгаарын цэрэгт алба хааж байсан бөгөөд халх голын дайнд оролцож байлдагчаас бага дэслэгч болтлоо эх орноо хамгаалах үйлст зүтгэж, 1945 оны чөлөөлөх дайнд явсан ахмад дайчны 1995 оны үнэмлэхтэй.

Б.Цэнзээ гуай баруун хилийн зэвсэгт тулгаралт байлдаанд оролцож явсан тухайгаа ийнхүү бичиж үр хойчдоо үлдээсэн байна. Мэргэн бууч байсан гэдэг. Дайны жилүүдэд цэргүүд 5 жилийн хугацаатай цэргийн алба хаадаг байсан юм. Энэ үед баруун хязгаарын байдал түгшүүртэй байна тэнд мэргэн буучаар очих тушаал өгч цэргээс халаагүй юм байж. Байтаг богдын тэр тулалдаанд генерал Лхагвасүрэнгийн тушаалаар томилогдон тусгай машинтай очсон. Надад байлдааны даалгаврыг зургаар харуулж, эсрэг талын мэргэн буучдыг устгах тушаал авч байг устгаад гарч ирэх, зам байрлалыг тодорхой заачихсан байдаг байсан. Тэндээс байг устгасны дараа хүн хүлээж аваад дараагийн байрлалд хүргэх ажлыг хариуцсан цэргүүд гүйцэтгэдэг байлаа. Байтаг богдын дайн эхлэхэд дайсны мэргэн буучдыг устгасан. Тэр байлдаан суман мөндрийн дор болж дайсныг түрүүлж устгахын төлөөнөө авхаалж самбаагаа дайчлахаас аргагүй байсан. 1944 онд Хасгийн таван овгийг Оспан удирдаж байсан. Энэ тулалдаан болсны дараа залуу жанжин Лхагвасүрэн генералтай овгийн ахлагч нар хэлэлцээр хийх хүсэлт тавьжээ.

Уг хэлэлцээрт Оспан баатар та нар бидэнд зэр зэвсгийн тусламж үзүүлээч, бид хасгийн хаант улсыг байгуулна. Бидний хасаг эрчүүд буцаж Шинжаан руу довтлон уйгур, шинжаан, түрэгийг чөлөөлөн Хасгийн хаант улсыг байгуулах зорилготой байна гэжээ. Хэлэлцээрт тийм зүйл тусгагдаагүй гэтэл

тэгвэл их удирдагч жанжин Чойбалсанг дуудуул гээд хоёр талын хэлэлцээр зогсож Чойбалсанг иртэл хойшлогдсон байна. Их удирдагч жанжин Чойбалсан гуайг ирэхийг хүлээж, цэргүүд тэнд 5 хоног амарч цэргийн эрдмийн гайхамшгийг үзүүлсэн юм. Чойбалсанг хүлээсэн тав хоногт би олон цэргүүдтэй танилцан монгол цэргүүд ч уран дасгал, явуут мориндоо мордох, морио хэвтүүлэх зэрэг янз бүрийн үзүүлбэр үзүүлж байсан юм. Хасгийн баатар Оспан 70 метр урт ширмэн бугуйлыг жороо морины ахиад газар хүргэхгүй эргүүлэн төрөл бүрийн үзүүлбэрийг чадамгай хийж байсан. Мөн мориныхоо гэдэс доогуур баруун зүүн тийш гарч давхих, морио зогсоох зэргээр морин эрдмийн гайхамшгийг үзүүлж байсан.

Тав дахь өдөр нь жанжин Чойбалсан ирж, тэдэнтэй хэлэлцээр хийгээд 4 омгийн хасгийг Баян-Өлгий рүү ачаалж, Оспаны харьяа овгийн ахан дүүсийг нь Ховд руу ачаалсан гэдэг. Энэ тулалдаанд явахдаа Завхан аймгийн Алдархаанаас Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын араар дайрч гэрийнхээ хажуугаар гарсан юм байж. Гэртээ хариагүй захиа ч бичээгүй маш их удсан тул гэр рүүгээ гүйгээд л оччихмоор харагдаж байсан гэдэг. Энэ тулалдаанд ороход нь зориулж казах үг хэллэг зааж байсан юм. Богино хугацаанд ойр зуур казахар ярьдаг болсон. Гэртээ хариагүй олон жил болсон учраас жанжин Лхагвасүрэнд хүсэлт тавьж өгсөн үүрэг даалгаврыг онц сайн биелүүлсэн тул 1947 онд цэргээс халагдан гэр орондоо ирсэн гэж ярьж байсан. “Манай өвөө Бэгзийн Цэнзээ нь Монгол эх орныхоо дархан хилийг хамгаалах, тусгаар тогтнолынхоо төлөө халуун амь, бүлээн цусаа үл хайрлан тэмцэж явсан эрэлхэг дайчин өвөөгийнхөө гэгээн дурсгалыг хүндэтгэн мэхийе” хэмээн ач зээ нараас нь энэхүү дурсамжийг бичиж ирүүлсэнд гүн талархал илэрхийлж байна.

ДАШИНЖИДЫН ЛУТЖАВ



Д.Лутжав нь Говь-Алтай аймгийн Цогт сумын нутаг Баянтоорой хэмээх газар 1914 онд ард Дашинжидын 8 дахь хүүхэд болон төрсөн. Эцэг, эхээсээ 10-лаа дээрээ 4 ах 3 эгчтэй 2 эмэгтэй дүүтэй байсан гэдэг. Лутжавын хүү Ринадорж гуайн дурсамжаас сурвалжлан бичлээ. “Манай аав бага наснаасаа эхлэн хүнд хэцүү амьдралыг туулж ирсэн тухайгаа бидэнд зарим зүйлийг ярьдаг байсан. Одоогийн Говь-Алтай аймгийн Цогт сумын нутгаар Хятадын зүүн хойд Шинжаан Уйгарын бүс нутаг нь албан ёсоор БНХАУ-ын бүрэлдэхүүнд багтах аас өмнө хасгуудын зарим хэсэг нь хаана ч харьяалагддаггүй манай улсын хил орчмын сумдын ард олныг дээрэм, тонуул хийж амьдардаг байж. Энэхүү хасгууд Атас богд уулын чиглэл Цогт сумын нутаг дэвсгэрээр хил даван ирж ард иргэдийг тонон дээрэмдэх үеэр Лутжав тэгэхэд бага хүүхэд байсан ах Очиржав, Таадаг нартайгаа амьд гарахын тулд аргагүйн хүчинд автагдан хилийн чанадад мал хөрөнгөтэйгөө олзлогдон туугдан гарчээ.

Тэр үед ард биднийг өмгөөлөн хамгаалах эр цэрэг, хүн хүч ч бараг байсангүй учраас дээрэмчид дуртай цагтаа орж ирээд хүссэн юмаа чөлөөтэй аваад гарч байсан. Ардын хувьсгалаас өмнө 1912 оны оны үед Хатанбаатар Магсаржавын цэрэг Ховд хотыг манжийн амбанаас чөлөөлөхөд, баруун хилд байсан Дамбийжанцан ард олноос элсүүлсэн авсан монгол цэргүүдийг удирдан энэ дайнд идэвхтэй оролцож алдар нэр олсон байжээ. Үүний дараа хязгаар нутгийг Хасгийн дээрэмчдээс хамгаалуулах зорилгоор Дамбийжанцанг түр баруун хязгаарыг хамгаалах сайдаар томилогдсон үед хасгийн дээрэмчдийг шахан зайлуулахад зохих үүрэг гүйцэтгэсэн болохоор арга буюу манайх Жа ламын тэмээн сүргийг хариулж байсан юм.

Эрийн цээнд хүрсэн тул Цэргийн албанд татагдан баруун хилд алба хааж байгаад 2 цэргийн хамт хилийн хайч эргэх гэж яваад хасгийн дээрэмчидтэй тулгарч 2 цэрэг маань алагдаж би өөрөө зүүн хөлдөө хүнд шарх аваад дайсанд баригдан хүргэгдсэн ажээ. Тэндээ 2-3 жил шарх сорви маань эдгээд биеэ тэнхрүүлсний дараа 5 цэргийн хамт оргон нутгийн зүгт явж байгаад дээрэмчдэд нэг цэргээ алуулаад дөрвүүлээ шөнөжин зам буруулан зугтааж 1 сар орчим хээрээр дэр хийж замдаа өмхийрсөн худгийн усаар ялзарсан үхрийн эврээр хутган амаа чийглэн байж амь гарсаар нутгийнхаа барааг харсан юм санж. Тэр хамт ирсэн хүмүүсийн хоёр нь Эрдэнэ сумын харьяат ахмад дайчин Төмөр, Цогт гэдэг байсан, би нөгөө цэрэгтэйгээ Цогт сумынхаа нутагт эсэн мэнд ирсэн билээ. Хамт баривчлагдан явсан нөхөд хүний нутагт үхэж, шархадсан тохиолдол бишгүй л гардаг хамгийн аймшигтай нь дайсны гарт баригдан тамлуулахаас илүү өлсгөлөнгөөр тураалдаа орж бурхан болж байгаа нутаг нэгт ахан дүүсээ харахаар үнэхээр сэтгэл эмтэрч хамгийн харамсмаар зүйл байдаг. Бид эцсийн бүлэгт хар амиа бодохоос илүүтэй төрөлх нутгийнхаа газар шороо, ард олныхоо ирээдүйн амар амгалан аж төрхийн төлөө амь насаа золин зүтгэж яваа болохоор сэтгэл уужран зориг орох шиг болдог юм“ гэж ярьж билээ.

Д.Лутжав нь 1939 онд Эрдэнэ сумын харьяат Аюуш гэдэг хүнтэй сууж Ринадорж, Хоролсүрэн гэдэг хоёр хүүхэдтэй тэд нар нь одоо эсэн мэнд орон нутагтаа амьдарч байна. Д.Лутжав нь эх орноо хамгаалах үйлст хүчин зүтгэсээр 1941 онд идэр залуу насандаа Дотоодыг хамгаалах газрын цэрэгт дайчлагдан морин өртөөгөөр Завхан орж Хогнин, Лувсандэмбэрэл гэдэг нутгийнхаа 2 хүнтэй хамт зүүн хязгаарт Дотоод яамны ар талыг тохинуулах үйл ажиллагаанд оролцож явсан нь эх орноо хамгаалах үйлст амь насаа зориулан үнэтэй хувь нэмэр оруулж явсан ахмад дайчдын нэг мөн билээ.

Цагаан хайрхан эрдэнэ сан” ТББ -ын тэргүүн Дашнямын Жанчивдорж

ЖАМСРАНГИЙН БАДАМЖАНЦАН



Говь -Алтай аймгийн Эрдэнэ сумын уугуул баруун хилийн эрэлхэг дайчин сумангийн дарга ахлах дэслэгч Жамсрангийн Бадамжанцангийн намтрын хуудаснаас сөхөн бүдгэрсэн гавьяаг тодруулах зорилгоор түүний хүү онцгой байдлын хурандаа Б.Жаргалсайханы бүтээсэн “ Сүлдэт баганад мөнхөрсөн эрэлхэг хилчний удам” хэмээх номын суваргаас зохиогчийн зөвшөөрлөөр сэдэвлэн орууллаа. Ж.Бадамжанцан нь 1920 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Засагт хан аймгийн Ёст бэйсийн хошуу, эдүгээ Говь-Алтай аймгийн

Эрдэнэ сумын нутаг Идрэнгийн нурууны “ намаржаа” гэдэг газар ард Жамсрангийн 13 дахь отгон хүү болон мэндэлжээ. 1939 онд олон улсын байдал хурцдаж байсан тул Засгийн газраас зохих арга хэмжээ авч шинээр анги салбаруудыг эмхлэн байгуулж, улс даяар цэргийн өргөн дайчилгаа зарлахад нутгийнхаа 40 гаруй залуусын хамт цэргийн албанд морджээ. 1939-1942 онд Хилийн цэргийн тусгай хороонд алба хааж байхдаа Галчийн мэргэжил олгох 2 сарын курст суралцан ахлах галчийн мэргэжил эзэмшин сурлагаараа шалгарч нэгдүгээр байр эзэлж байв. 1942 оны 6 дугаар сард Хязгаарын цэрийн төв сургуульд шалгалт өгөн тэнцэв.

1945 оны 6 дугаар сард сургуулиа онц дүнтэй дүүргэн 13 төрлийн буудлагын зэвсгийн шалгалтад 100 хувийн амжилт үзүүлж сургуульдаа салаан дарга, тактикийн багшаар үлджээ. Ийнхүү ирээдүйд ямархуу цэргийн дарга болохоо батлан харуулсан хэрэг байж. Баруун хилийн цагийн байдал зэвсэгт тулгаралтын мэдээг сонсож зүгээр хараад тэвчсэнгүй залуу офицер эх нутгаа хамгаалахаар зориг шулуудан 1946 оны 1 дүгээр сард баруун хилд алба хаах хүсэлтээ гаргахад нь сургуульд чадварлаг багш чухал хэрэгтэй байлаа ч захирал нь дээш уламжилснаар Ховдын хилийн 5 дугаар отрядад сумангийн

туслахаар томилогдон баруун хилд алба хаах намтрын хуудас нээгдсэн түүхтэй аж. Хилийн цэргийн домогт 5 дугаар отряд хүн хүч дутмаг хамгаалах газрын зурвас өргөнтэй, байлдааны зэвсэг техник, сургалт төдий сайнгүй байсныг дайсан овжин ашиглаж их хүчээр түрэмгийлэн алж хядах, дээрэм тонуул хийх үйл ажиллагааг улам эрчимжүүлж байжээ. Отряд өөрт буй хүчин чадлынхаа хирээр няцаалт өгч байсан ч зарим үед аргагүй хүч мөхөстөх ухрах, ялагдах үе ч гарч байсан. Гэвч отряд маань энгийн ардын групп болон Ховдын ардын цэргийн 4 дүгээр морьт хорооны дэмжлэгтэйгээр тулалдаж хилээ батлан хамгаалсаар байв.

Баруун хилд дайны байдал хүндэрснийг Төр засгаас анхаарч 1947 оны 2 дугаар сард шинээр 6 дугаар отрядыг эмхлэн байгуулахдаа баруун, зүүн хязгаарын заставуудаас байлдааны туршлагатай чадварлаг дарга, цэргүүдээр бүрдүүлж 5 дугаар отрядаас сумангийн дарга ахмад Ж.Нэхийт, туслах ахлах дэслэгч Ж.Бадамжанцан, зүүн хязгаараас заставын дарга ахмад С.Лхагвадорж нарын мэргэн бууч, офицер дайчдыг сонгожээ. 1947 оны 6 дугаар сарын 19-30 өдрүүдэд 170 км хол орших Шинжааны Цонж хотоос 700 гаруй Оспан, Гоминданы цэргүүдтэй нэмэлт хүч татан түрэмгийллээ улам хурцатгав. Давуу хүчинд бүслэгдсэн хилчид сүүлчийн сумаа өөртөө зориулж, эцсийн гранатаа тэсэлж баатарлагаар амь үрэгдсэн хилчид олон гарч байв. Энэ тулаанд ахлах дэслэгч Ж.Бадамжанцан эрэлхгээр үүргээ гүйцэтгэсэн байна. 1947 оны 8 дугаар сарын 30-нд ДЯЯ-ны сайдын тушаалаар зүүн хязгаараас 17, 20, 23, 24, 31 дүгээр отрядаас тус бүр зургаан заставыг 5, 6 дугаар отрядын мэдэлд шилжүүлжээ. 1947 оны сүүлчээр Байтаг богдын тулаан өндөрлөсөн ч дайсны халдлага тасралтгүй үргэлжилсээр байв. 1948 оны 5 дугаар сарын 27-28-нд шилжих шөнө Ховдын Булган сумын Бага Хавтаг уулаар хил даван орсон Оспаны дээрэмчдийг устгахаар 6 дугаар отряд бүх хүчээрээ хилээс дотогш 70 км-ийн гүнд Мэргэн ууланд бүслэн авч тулалдсан билээ. Энэ байлдаанд ямар үүрэг гүйцэтгэсэн талаар “Соёмбо” сонины 2001 оны нэг дугаарын нийтлэлд сурвалжлагчид Ж.Бадамжанцангийн өгсөн ярилцлагаас: “Мэргэн уулын орчмоор Хасгийн 50 гаруй дээрэмчид хил даван орж ирлээ гэсэн мэдээ авч ахмад Ж.Нэхийтээр ахлуулсан групп Шар Дүнг гэдэг газраар дамжин Мэргэн уулыг

бүслэн пост гаргасан юм. Бүтэн өдөржин хүлээлээ Оспаны цэргийн бараа харагддаггүй бид Булган гол хүртэл тагнан туршихаар дөнгөж хөдлөөд байтал манай отрядын хойд талаар ачаа бараа тэгнэсэн цуваа гарч ирлээ. Ж.Нэхийт маань тэднийг хармагц өнөөх дээрэмчид энэ мөн байна бид хилийн шугамын наагуур амдан тойрохоор явж байхад манай 2 онгоц тэднийг бөмбөгдөж тэд Мэргэн уул руу зугтан гарч хориглолоо.

Ардын группийнхэн уулын хойд талаар бид баруун урдуур нь тойрч очин тулаанд оролцлоо. Энэ үед уулын оройд бүгсэн дайсанд ойртон гал нээж тал руу тэднийг буулгах үүрэгтэйгээр ахмад С.Лхагвадорж урагш давшин уулын нэлээд өндөр хэсэгт очсон юм. Үд өнгөртөл түүнийг байрлалаа эзэлтэл бид хүлээлээ. Тэр үе үе буудалцаад байгаа бололтой, тэгснээ хэсэг чимээгүй болчхов. Ж.Нэхийт дарга намайг дуудаж нэг цэрэг дагуулаад чи яв. С.Лхагвадоржийн амьд эсэхийг мэдээд түүнд тусал гэж үүрэг өглөө. Би хад чулуугаар халхавчлан С.Лхагвадорж дээр хүрч очиход тэр маань шархтан үхлүүт хэвтэж байв. Толгойг нь түшиж өндийлгөхөд намайг хэсэг харж ямар нэгэн юм хэлэх гэснээ чадалгүй нүд аньсандаа. Хажууд нь гар буу нь шороонд дарагдсан байсныг авч тэнд сайтар далдлаад эмнэлгийн тусламж үзүүлэхээр ирсэн дайчдад С.Лхагвадоржийг үүрүүлээд явуулсан юм. Би дараагийн даалгавраа биелүүлэхээр Ж.Нэхийттэй даргатайгаа холбоо бариад мориндоо мордон нөгөө цэргээ дагуулсаар давхитал миний өмнө нэлээд өргөн жалга тааралдав. Морио харайлгахаар урагшаа ухасхийтэл баруун хөлийн нум руу хүнд юмаар цохиод авах шиг болж би морьтойгоо гүн жалганд өнхрөн уналаа. Өндийх гэтэл сайран дээр шинэхэн цусны дусал гялтганан, лавлаад хартал зүүн хөлийн гутлын түрийнээс цус нөжрөн гоожиж байв. Хамт явсан цэрэг маань сувилагч олж ирэн цусыг тогтоож маргааш нь би онгоцоор эмнэлэгт хүргэгдсэн. Сумангийн дарга Ж.Нэхийт бид хоёр нэг жил хамт ажилласан. Ховдын отрядад ажиллаж байгаад ирсэн их шийдэмгий газар орноо сайн мэддэг хүн байсан тиймээс Мэргэн уулын тулгаралтад групп ахлуулсан байх. Хожим Ж.Нэхийт, С.Лхагвадорж нарт Монгол улсын баатар цол олгосон байдаг". Ж. Бадамжанцан нь хилийн цэрэгт 1946- 1951 он хүртэл Баруун хил хязгаарын бүхий л тулгаралтад оролцож мэргэн бууч гэдгээ нотлон харуулж, эх орон, газар

нутгийнхаа төлөө халуун амь, бүлээн цусаа урсган тэмцэж явсан ахмад дайчин энгэртээ “ Бид ялав” Байлдааны хүндэт медаль гялалзуулан цэргээс халагдсан ажээ.

Тэрээр 1996 онд Байлдааны гавьяаны улаан тугийн одон, бусад ойн медалиуд хилийн цэргийн 6 дугаар отрядын 50 жилийн ойгоор “ Онц хилчин” тэмдгээр шагнагдаж хилийн 155 тоот баганыг түүний нэрэмжит болгожээ. Цэргээс халагдаж ирээд Эрдэнэ сумын “Чойбалсангийн зам “ нэгдэлд 32 жил мал маллан сумын сайн малчин, алдарт уяач, 2000 онд 80 жилийн ойгоор “Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч “ Ахмад дайчны хөдөлмөр алдыг тэмдэглэж Хүндэт дэвтэрт нэрийг нь бичиж гавьяа зүтгэлийг мөнхөлсөн байна.

“Цагаан хайрхан эрдэнэ сан” ТББ -ын тэргүүн Дашнямын Жанчивдорж

ШАГДАРЫН ГОЧОО

Шагдарын Гочоо нь багадаа эцэг эхээсээ өнчирч хэдэн дүүгээ хүний зэрэгт хүргэхийн төлөө ан гөрөө хийж, эцэг эхийнхээ үүрэгт ажлыг санаачлан гүйцэтгэхээс эхлэн хүнд хүчир болгонд бие даан амьдралаа авч явах хэрсүү ухаан суулгажээ. Цэргийн албыг хааж нутагтаа ирээд хошууны зарлагын ажлыг хийж амьдралаа залгуулдаг байж. Гэтэл гадаад, дотоодын эрх ямбаа алдсан шунахай хэсэг бүлэг хүмүүсийн үгэнд хууртагдан хилийн чанадад нүүж яваад эргэн ирж элэг нэгт нутаг орныхоо ард түмнийг зэвсэг агсан дээрэм хийдэг хүмүүсийг паартагчингууд хэмээн нэрлэдэг байжээ. Тэр паартагчингуудыг цагаан гэгээн гэж өргөмжлөгдсөн лам удирдан хошуу нутгаа дээрэмдэж байв. Дээрэмчид 1932 оны 8 дугаар сарын орчим Эрдэнэ сумын нутагт орж ирээд сумын дарга лангайн Пүрэвийг алж, хоршоог талж, цай, даалимба, будаа, гурилыг нь тэмээнд ачин, сумын захиргааны гэр, бусад үлдсэн хөрөнгийг нь шатааж, түймэрдээд, бэлчээрт явсан айлын тэмээ, адуу малыг дээрэмдэн зэргэлдээх Чандмань сум руу явжээ. Тэр үеэр Ш.Гочоо авхаалж самбаа гарган мориор зугтаж амьд үлдсэн байна.

Дээрэмчид хилийн чанадад бүгж байгаад байн байн ирж ард олны өнгөтэй хувцас, эд бараа, мал хөрөнгө, үзэсгэлэнт охид, бүсгүйчүүдийг олзолж аваад буцдаг байж. Ш. Гочоо энэ байдлыг зүгээр харж суусангүй ямар нэгэн зүйл хийхээр шийдэж Цагаан гэгээнд итгэл олохын тулд тэдэнтэй нийлж буй дүр үзүүлэн гэр орноо ачиж малаа туугаад хадам эцэг Бэгэжав, хүүхдүүдийн хамт нүүж явсан байна. Тэгээд паартагчинтай хамт Идрэнгийн нурууг давахын өмнөх өдөр нь Жанзандоржид газар зааж толгой сэргийлэхэд яв гэж дээрэмчний удирдагч тушаажээ. Гочоо гэрийнхэндээ “Надад толгойн сэргийлэхэд гарах тушаал өглөө би эдэнтэй хэзээ ч нийлэхгүй ямар нэгэн арга хэмжээ авахыг бодъё, харин та нар тэмээнийхээ ачааг нурахаар ачаалж. засах дүр эсгэн хоцорч, Идрэнгийн нуруунд 2 гүн жалга байдаг юм, Түүний аль нэгэнд орилоо тэмээ, нохойныхоо амыг боогоод нуугдаж бай” гэж захиад цааш явжээ.

Гочоо, Жавзандорж хоёр толгойн сэргийлэхийн үүргээ гүйцэтгэж явтал нэг толгойн энгэрт хэдэн аргаль идээшилж байгааг хараад Гочоо Жавзандоржид “Хоёулаа энэ аргалиас нэгийг буудаж, махыг нь ганзагалаад явъя. Бидэнд хоол хэрэгтэй” гэжээ. Жавзандорж зөвшөөрч “Тэгье хоёулаа онь холбож буудна шүү миний тохиогоор гохоо дараарай” гэж тушаажээ. Анчин хүний гярхай санаагаар Гочоо тушаал ёсоор бугаа шагайж байснаа гэнэт бууныхаа амыг хажуу тийшээ эргүүлэн, Жавзандоржийг буудаж алаад морь, буу сум, дуранг нь аваад зам буруулан зүүн тийшээ мориныхоор хар хурдаар 2 өдрийн газар давхин зам буруулан одож нутгийн ивээлд багтан Идрэнгийн нурууны гүн жалганд нуугдаж байсан гэр орондоо очиж 1932-1934 он хүртэл 2 жил шахам тэр л нуруундаа гөрөөс алж, гэр орныхоо хүмүүсийг тэжээж байгаад 1934 оны сүүлчээр Эрдэнэ сумандаа нүүж ирцгээжээ.

Ш.Гочоог сумын ард олон голдуу Хунжийн Гочоо гэж дуудаж заншсан байлаа. Хунж гэдэг нь түүний ээжийнх нь нэр байжээ. Ш.Гочоо 1934-1936 оны хооронд ард олон түүнд итгэл үзүүлэн Эрдэнэ сумын даргаар сонгон ажиллуулжээ. Учир нь сумын дарга байхдаа ард олныхоо итгэл найдварыг хүлээж үргэлж санаж сэддэг тул түүний өгсөн үүрэг даалгаврыг ёсчлон биелүүлэхээс аргагүй маш нэр хүндтэй дарга байжээ. Тэр үед сумын хоршоонд

маузер буу цөөвтөр ховор ирдэг байсан. Анчид түүнийг худалдан авахыг их сонирхдог учраас сумын даргын зөвшөөрөлтэйгөөр худалдах үүргийг хоршооны даргад өгдөг байжээ. Тэр бууг худалдан авсан анчин хасгийн дээрэмчин ирсэн мэдээ авмагц морь унаатайгаа 30-аас доошгүй сумтайгаар дуудсан газар бэлэн байхаар тохирч өргөдлөө цохиулдаг журамтай байжээ.

Гэтэл 1936 оны өвөл хасгийн дээрэмчид Чандмань хайрхны зүг зугтан, улаан хадан уулын энгэрт тэмээгээр хүрээлүүлэн буудалласан тухай мэдээг нутгийн иргэн Чимэднамжил суман дээр очиж Гочоо даргад хэл хүргэж, Ш.Гочоо дарга тэр шөнөдөө 11 морьтон анчныг яаралтай цуглуулан Чандмань хайрхны зүг явж хүрээд нэгэн жалганд морьдоо хүнээр харуулаад хасгуудын бүгж байгаа газар ойртон тойрч бүсэлсэн байдалтайгаар ашигтай байрлал сонгон эзэлжээ. Гочоо дарга “Үүр гэгээрэхээр миний тохиогоор гал нээ” гэсэн тушаал өгчээ. Удсан ч үгүй үүр цайж байтал нэг хасаг эртлэн босоод төмөр хувингаа дүүжлэн доор нь гал түлж байснаа мориныхоо тохмыг аваад 41 чулуугаар мэргэлж эхэлснээ гэнэт муухай хашхиртал бусад нь босоод мориндоо мордохоор нь энд тэндээс нь гал нээтэл хасгуудын сум ч толгой дээгүүр шунгинаж, зарим сум ч хаданд тусан исгэрч байлаа. Хасгууд морьдоо унаад, богцтой махаа ганзагалан зугтаад алга болжээ. Үлдсэн хасаг нь бидэнтэй буудалцаад нэг нь нам буудуулж, нөгөө нэг нь хүнд шархадсан бололтой байв. Биднийг очиход тэр дөнгөж амьсгаатай байгаад удалгүй үхсэн гэж 11 морьтны нэг Ш.Бадамбазар хожим ярьсан байдаг. Эдгээр хасгуудын дээрэмдсэн зүйлүүд нь үлдсэн бөгөөд үүнд хөнгөн пулемёт 2, винтовын сум өдий төдий, тэмээ, морьд, хонь, үхэр ачаа бараа зэрэг зүйлүүдийг дээрэмчдээс салгаж ардуудад тараан өгч, буу сумыг данслан аймагт хураалгасан ажээ.

Э.Баатарцэрэнгийн дурсамж: Сонгино хайрхны дээд талд сум нэгдлийн дарга байсан Шагдарын Гочоо нутгийн иргэн/ Ханхар/ Дэндэв нар нэг өглөө эртхэн Чандмань хайрхны орой дээрээс дурандаж байтал гурван морьтой хасаг явж байхад нь гарч ирэх замыг отоож байгаад нэг хасгийг нь буудаж алтал нэг нь шархадсан боловч хамт явж байсан нөхрийнх малгайны оройг цоо буудаж байсан

тун мэргэн бууддаг дээрэмчид байсан нөгөөх нэг нь майхан улаанаар даваад зугтаад алга болсон гэж ярьдаг байсан.

Ш.Гочоогийн дүү Согсоон, дүү Лувсандорж нь эрэлхэг зоригтой ахмад дайчин байсныг энэ номонд бас бичиж үлдээлээ. Нутгийн иргэн Сүрэнхорын Бэгзжав дурсан ярихдаа: “Шагдарын Гочоо 1934-1936 онд сумын дарга хийж байхдаа Довдон аграмба хэмээх Богдын төлөөний хүн ирээд Ёст бэйсийн хошууны Сангийн далайн хийдийн талаар сумын дарга ард олонд маш их ухуулга сурталчилгаа хийдэг байсан ч сумын даргын заримч шударга, ард иргэдээ өмгөөлөн хамгаалсан тэмцлээс болж төдийлөн амжилтанд хүрээгүй” гэж ярьдаг байсан. Мөн Ш.Гочоогоор удирдуулсан анчид хасгуудтай удаа дараа зэвсэглэн тэмцэж байсан бөгөөд “Шуманз” хэмээх газар хасгуудтай тулгаран байлдаж байгаад Рааш Даржаа Ш.Бадамсүрэн нар баригдаж Ш.Гочоо хориглон байлдаж байгаад амьд гарсан байдаг”. Ш.Гочоо 1941 оноос хойш нутагтаа мал маллаж байгаад хөдөлмөр зүтгэлээрээ шалгарч улсын сайн малчин, улсын тэргүүний анчин хүн байсан ажээ.

“Цагаан хайрхан эрдэнэ сан” ТББ-ын тэргүүн Дашнямын Жанчивдорж

ШАРАВЫН БАДАМБАЗАР



Говь-Алтай эрдэнэ сумын даргаар ажиллаж байсан Шаравын Бадамбазар гуай нь бага залуугаасаа ан гөрөө хийж буу зэвсэг сайн эзэмшсэн тул нутаг нэгт ард олныгоо дээрэмчдээс хамгаалах тэмцэлд тууштай оролцож байсан тухайгаа өөрөө болон хүү Б.Дагвадоржийн дурсамж ярианы эх сурвалжтай зарим зүйлийг бичиж байна. Ш.Бадамбазар 1913 онд Эрдэнэ сумын нутагт эцэг Шаравын гэр бүлд

төрсөн. 1932 оны хавар паартагчингууд Эрдэнэ сумын нутгаар дамжин ирэх үед Бадамбазарыг Чандмань сумын хоршооны дарга Ёгор гэдэг хүн дуудуулжээ. Бадамбазарыг яваад очтол “Паартагчингууд Эрдэнэ сумаар ирэх сураг гарлаа. Хоёулаа хоршооны цаасан мөнгийг хаданд аваачиж нууя” гэж хэлээд цаасан мөнгөө богцонд хийж ганзагалаад Ботгоны голын урд ууланд мөнгөө нуугаад явж байтал Ботгоны голын урд урдуурт зусаж байсан айлуудын хавиар олон морьтой хүн багшран явж харагджээ. Ёгор гуай архинд нилээд дуртай учраас “Энд айлын хүүхдийн сэвлэг үргээж байгаа юм шиг байна хоёулаа очье” гэхээр нь би “ээ болохгүй байхаа өнөөх паартагчингууд нь ирсэн юм бишүү” гээд татгалзтал “Паартагчингууд буцсан байлгүй” гэж үгэнд оролгүйгээр давхиад очсон чинь паартангчингууд тэр хоёрыг барьж авчээ.

Ёгор гуай Цагаан гэгээнд мөргөн адис авч зангиа зүүгээд гэр орноороо паартагчинг дагаж нүүхээр болжээ. Харин Бадамбазарыг паартагчингийн цэрэг болгож буу зэвсэг тавьж өгөх гэхэд нь манай нутгийн Бандинхүү гэх хүн “Энэ хүүг би ажилдаа туслуулж явъя” гэж Цагаан гэгээнээс гуйхад дуртай зөвшөөрч цэрэг болгохоо больжээ. Тэр үед Бадамбазар 19 орчим настай залуу байв. Бандинхүү нь Цагаан гэгээний эд хөрөнгө, адуу маылг харж хамгаалдаг итгэлтэй хүн байжээ. Паартагчингийн ахлагч Цагаан гэгээн нь нэгэн сайхан мөнгөн эмээл хазаартай, тэлмэн жороо морь унаад л ташаандаа нагаан буу зүүсэн бүдүүн биетэй хүн саахалтын хооронд явж байгааг харж байлаа. Орой болоход Бандинхүү гуай Бадамбазарт өнөө шөнө гэгээний морийг сайн идүүлж харж хонооро, юмаа сайн хараарай маргааш буцах юм шиг байна”. Гэж хэллээ. Бадамбазар шөнө гэгээний бор морийг унаад өөрийнхөө морийг хөтлөөд Говь-Алтай нурууны Эмээлцэгийн өвөрт байсан гэртээ давхиад очтол ээж дүү хоёр нь байна гэнэ. Гэрийн хананд өлгөөтэй байсан хонины нэг гуаыг огтолж аваад “Намайг үүгээр ирсэн гэж хэнд ч хэлж болохгүй” гэж ээж дүү хоёртоо захиад Эмээлцэгийн нурууны арын жалганд хоёр морио чөдөрлөж орхиод махаа шарж идээд хоножээ. Өглөө нь буу үүрсэн хоёр морьтой хүн Бадамбазарын гэрийг чиглээд ирж байгаа харагджээ. Тэгэхээр нь ээжийг минь алчих байхдаа яадаг билээ гээд сэтгэл түгшин суув. Удалгүй хоёр морьтон ачааныхаа хойноос давхиад алга болжээ. Тэр өдрөө Бадамбазар байгаа газраа бүгж хоноод

маргааш өглөө нь дүү Чойжилжав нь хонио бэлчээгээд Эмээлцэг өөд явтал очиж ээжийгээ асуутал паартагчин “Чиний хүү гэгээний морийг хулгай хийж унаад оргосон хүүгээ хаана байгааг хэл тэгэхгүй бол чамайг буудлаа гэхэд ээж нь “Би мэдэхгүй 3 хоногийн өмнө Чандманы төв рүү л явсан алга байна гээд юу ч хэлэхгүй болхоор “тийм бий вий “ гэж хэлээд ээжийн гуя руу жадлаад явсан. Ээж маань цавагны эсгийнээс урж тавиад цамцаараа боо гэсэн гэж хэлхээр нь зохих ёсоор гүйцэтгэсэн боловч цус нь тогтсон ч ээжийн бие муу хэвтэж байгаа гэв. Би ээж дээрээ хурдан очиж эм тан олж өгч, ээжийгээ сар гаруй асарч байж зүгээр болгосон.

Гэгээний жороо морь Чандмань сумын нэг баян айлын морь байсныг эзэнд нь эргүүлж өгөөд эмээл хазаар нь хэнийх болох нь үл мэдэгдсэн тул Чандмань сумын тусгай төлөөлөгч намайг дуудаж байцаалт аваад мөнгөн хазаар эмээлийг хурааж авсан. Ш.Бадамбазар нь энэ мэтээр паартагчингуудтай олон удаа тэр үеийн сумын дарга байсан Ш.Гочоогийн удирдлаганд дор зэвсэгт тулгаралтад оролцож энгийн ард олноо хамгаалдаг байсан хэмээн ярьдаг байж.

Ш.Бадамбазар гуайн нэгэн дурсамжид: “Хасгууд гурван гайхалтай зүйлийг чадамгай эзэмшсэн байсан мэргэн бууддаг хадны завсраар ташуурын үзүүрт малгай гаа өлгөөд дөнгөж цухуйлгаад авахад л малгайг минь цоо бууддаг юм, морьд нь хаданд буюу бартаатай газрыг түргэн туулах чадвар сайтай, 41 чулуугаар мэргийг гайхалтай эзэмшсэн тул урьдчилаад цаг үеийнхээ байдлыг мэдчихдэг түүндээ тохируулж аливаа бэрхшээлээс бултаж чаддаг байсан. Түүнээс илүү зориг овсгоо гаргаж дайснаа устгах, хохирол бага амсах шаардлага тулгардаг байв.

Ш.Бадамбазар 1933 онд 20 настай цэргийн албанд мордож Дорнод аймгийн Тамсагийн 6 дугаар дивизэд алба байхдаа 1936 оны 1 дүгээр сарын 28-ны шөнө харуулд гархаар бэлтгэж байтал гэнэт өндөр халуурч оронд нь нөгөө бага дарга Ш.Гонгор 2 цэрэгтэй хамт харуулд гарч Булан дэрсний харуулаас зүүн тийш цагаан ухаа дээр үүргээ гүйцэтгэж байтал дайсны зэвсэг бүхий 10 морьтон ирж явгалан буудаж эхэлтэл Ш.Гонгор нэг цэргээ холбоо бариулхаар буцааж нөгөө цэрэгтээ морио бариулан ганцаараа байлдаж дайсны нэг цэргийг

устган орос, япон винтов тус бүр нэгийг олзлон авч бусад нь хилээс зугтан зайлжээ. “Гонгор бид хоёр нас чацуу хөнгөн шингэн, сэргэлэн цовоо, авхаалж самбаагаараа ижил төстэй залуус байсан. Тэр устгагдсан дайсан нь монголыг эзлэх маш нууц төлөвлөгөөтэй японы нөлөө бүхий хурандаа байжээ. Үүний улмаас Ш.Гонгор БНМАУ-ын баатар цолоор шагнагдсан” ажээ. Ш.Бадамбазар 1937 онд цэргээс халагдаж ирээд 1937-1939 онд Эрдэнэ сумын дарга болж сум орныхоо ард олны төлөө эзэрхэг дээрэмчидтэй амь хайрлахгүй тэмцэж гавьяа байгуулсан ахмад дайчны нэг байжээ.

“Цагаан хайрхан эрдэнэ сан” ТББ -ын тэргүүн Дашнямын Жанчивдорж



БАТСУУРИЙН САМБУУ 1927 онд Завхан аймгийн Дөрвөлжин суманд төрсөн. 1948-1951 онд цэргийн алба хаасан. Энэ хугацаанд Баруун хилийн 5 дугаар отрядад алба хаасан.

1951 оноос цэргийн албанаас халагдан ирээд нэгдэлд анхны гишүүн, малчин хийж байсан.

1959 онд уул уурхай, Булган, Дорнод, Хэнтий, Дунд говь газруудад механикийн ажил хийж байсан. 1969 онд Тээврийн

авто баазад механик инженерийн аж

ил хийж байсан.

Цэргийн гавьяаны улаан тугийн одонтой.

Хавсралт илтгэлд зориулав.

БЯМБЫН ШИЛЭГ:

Би 1926 онд Баясгалангийн Бямбаагийн 2 дахь хүү болон Байтдагт төрсөн. Аав ээжтэйгээ 8 нас хүртлээ амьдарч байгаад 8 настай байхад ээж Түмэнбаяр нас барсан түүнээс хойш авга ах Очир, Бэргэн Дүгэржав нарын халамжид 20 нас хүртлээ өсөж хүмүүжсэн. Би анх 1944 онд 19 настайдаа Хил хамгаалах сайн дурын группийн гишүүнд элссэн 1944 оны 11 дүгээр сард Б.Дорж генерал ирж группийн штабт үүрэг даалгавар өгсөн тэр үед хил тодорхой биш байсан. Уушигийн цаана Давсан түнгэ гэдэг газарт Хятадын цэрэг ирж байрласан байсан түүний цаана Байтдагийн хойд үзүүрт “Дотор хар” гэдэг газар ирсэн цэргийг нааш хүч нэмэгдүүлэхгүйн тулд замыг нь тосож байлдаж буцааж байсан. Манай 10 аад цэрэг 60-аад группийн гишүүд ар араасаа хүч нэмэгдүүлж нийтдээ зуугаад хүн байлдаж буцааж байсан. Ингээд би 2 сар гаруй болоод урд туссан сумнаас нүдэнд элс шороо цацарч нүд минь өвдөөд хэдэн хоногийн дараа Айжаа гэдэг хүнтэй намайг Булган сум руу буцаасан үлдсэн группийн гишүүд маань хавар 3 дугаар сард буцаж ирцгээсэн. Булган сумандаа ирээд хөхний сүү саалгах, тариагаар үрэх зэрэг арга хэмжээ авсан боловч өвдсөөр байгаад нэг нүдгүй болсон. 1946 оноос 1949 он хүртэл цэрэгт татагдаад нүднээсээ болж эрүүл мэндийн шалтгаанаар цэргийн албанаас хасагдсан. Тэр үед цэрэг 5 жилээр хаадаг байсан. 1945 оны 6 дугаар сарын үед Б.Дорж генерал ирээд группийн гишүүдийг Үрэнгийн шар сүм явуулахаар 300 орчим группийн гишүүд цуглуулж Булган сумын зусланд Хар балчгийн баруун салаад хурал хийгээд Үрэнгийн шар сүмийг эзлүүлэхээр хойш явуулсан. Шар сүмийн наан Түргэн, Сайхан булаг гэдэг газарт очсон. Тэнд очиход Жамъян даргатай Монголын цэргийн анги очсон байсан. Оросын Туркменистаны цэрэг ирнэ, түүнтэй хамтарч Шар сүм орно гээд хэд хоног хүлээгээд Туркменистаны цэрэг ирэхгүй болохоор зарим группийн гишүүд Булган сум руу буцсан хагас нь Туркменистаны цэрэг Хятадын Живне хотод байдаг гэнэ гээд Агваандорж ахлагчтай 80-аад хүн Живне хотыг Туркменистаны цэрэгтэй хамтарч эзлэхээр очсон та нар ирсэн сайн боллоо бидэнд энэ хотыг эзлэхэд туслалцаа хэрэгтэй байна. Туркменистаны цэрэг очоод бүслээд нэлээд удсан байсан маш том хэрмэн хашаатай байсан. Бид очоод хоёр хонож байтал өглөө үүр цайж байхад Туркменистаны цэрэг миномёт их бугаар хашааг нь сэт сэт буудаад бутлаад шороо тоос гэж харанхуй татсан манай очсон нөхөд бас дайрч ороод

буудалцаад Живне хотыг эзлээд тэр хотын Сүм байсан газарт ялалтын туг хатгасан. Тэр хотын мал нь олон хоног бүслэлтэд орсноос нэгнийхээ ноос идсэн байсан. Бид тэгээд буцаад Булган сумын Бумбат гэдэг газар ирээд байж байтал Хасгийн дээрэмчин ирж айлуудын адуу мал хөөж, Маваазын Цогтбал гэдэг хүнийг малаа хариулж явахад нь малыг нь туулгаад явж байсныг группийн хэдэн хүн араас нь хөөж буудалцаад Цогтбалыг малтай нь буцааж авч байлаа. Тэр үед Магдаан гэдэг хүн хасгийн суманд өртсөн билээ. 1945 оны 09 дүгээр сарын үед Авга ах Б.Бадамыг группийн штабаас дуудаж баруун тийш тагнуулд явах үүрэг өгсөн байсан тийшээ явж тэнд байсан айлуудыг наашаа явуулах ба байр байдлыг тагнаж мэдэх даалгавар өгсөн байсан. Бадам ах тагнуул болон хил хамгаалах ажилд явахдаа намайг морь малаа харуулах, бариулах зэргээр дагуулж явах дуртай байсан. Бид буцах замдаа Хятадын нутаг Хиагийн худаг гэдэг газар морио амрааж цай унд хийж уухаар бэлдэж байтал цаана толгой дээр буудахаар бэлдсэн хүмүүс байсныг хараад тогоо шанагаа орхиод жалга уруудан зугтаасан. Бид 5 хүн явж байсан Баясгалангийн Бадам, хар Нямаа, Зургаадайн Гончоо, Бямбаан Шилэг, Бальдаан Жигмэд гэсэн хүмүүс явж байлаа. Би жаахан хашин морьтой учраас ард хоцроод явж байгаад эргээд хартал тоос гарч дээрэмчид ирж байсан урд талд нэг толгой байсныг тойрч эргээд хасгуудын өнгөрөөсөн тэд 6 хүн явж байсан ард нь хоцорсон нэг хүнийг буудаж хаяад нэлээд оройтож хүмүүс дээрээ ирж байсан. Тэднийг манайхан хий буудаж зогсоогоод та нар яагаад хүн буудаж алж байгаа юм бэ гээд нэлээн маргаж байгаад нутаг, нутаг руугаа буцацгаасан. Тэгэхэд Бадам ах маань намайг яаж амьд гарч ирсэн тухай асуугаад миний хүү тийм сэргэлэн овсгоотой би тэднийг чамайг замдаа хороочоод ирсэн гэж бодсон гээд намайг татаж үнсээд уйлж байсан билээ. Бид буцаж очоод тогоо шанагаа аваад наашаа буцаж яваад Байтдагийн уртын гол өгсөөд явж байгаад Жигмэд бид хоёрыг толгойн сэргийлэхэд түрүүлж явуулсан бид 2 явж байгаад нуугдсан хүмүүс байж магадгүй гэж ярилцаад гэнэт морио эргүүлээд зугтаатал буун дуу тас хийж байсан ингэж явж байж нутагтаа ирсэн. 1944-1945 оны өвөл зуд болж айлууд их ядуу хэцүү байсан. Ингээд би 1946 оны 6 дугаар сард амьдралын эрхээр Алтай суманд ирж амьдарсан. Энэ нутагт ирээд 4 дүгээр багийн иргэн болсон. Намайг ирэхэд группийн гишүүд гэж 20-иод хүн байсан группийн ахлагч Доржийн Зоноров гэдэг

хүн байсан ирээд намар нь Цагааннуурын жинд явж ирсэн. Ингээд Хасуунаа гэдэг айлд өвөлжөөд байж байтал Халзаны хар хоншоор гэдэг газар Балжуурын Тогмидынд хасгийн дээрэмчин ирээд Тогмидыг буудаж хороогоод адуу малыг нь хөөж явсныг сонсоод группийн гишүүд Зоноров, Хоовоо, Шилэг, Түдэв, Манж бид нар араас нь хөөгөөд биднийг очтол хил даваад явчихсан байсан. 1947 он гараад Байтдагт Гоминданы цэрэг давж ирснийг мэдээд Завхан, Архангайгаас Байлдааны ангиуд ирсэн манайхаас Хөх толгойн 6 дугаар Отряд болон Жимбэхүү даргатай 2 дугаар сумангийн Наадаа төлөөлөгч группийн гишүүд цуглуулаад нийт 10 гаруй хүн болсон Наадаа төлөөлөгч цэргүүдийн хамт группийн ахлагч Зоноров, Хоовоо, Шилэг, Манж, Цэвгээ гэсэн 10 гаруй хүмүүс очиж тулалдаанд оролцож байсан. Тулж байлдахад Монгол талдаа нэлээд хүндрэлтэй байсан учир нь Гоминданы цэрэг их команд, бага команд гэж өндөрлөг газар байрласан учир тулж байлдахад хүндрэлтэй байсан. Ингээд байлдсаар байж гамингийн хорьж хэд хэдэн удаа тулалдаад байж байтал наанаас Онгоц очиж бөмбөгдөөд цэрэг зэвсгийн хүчээр хөөж гаргасан. Гамингийн цаас даваад явсны дараа группийн гишүүдийг буцаасан. Энэ нь 1947 оны 06 дугаар сараас 09 дүгээр сар хүртэл болж байлаа.

1947 оноос өмнө хилийн застав гэж байгаагүй Цонжийн бор толгойд 2 дугаар суман, Булган сумын Хаацад Гэрэлчулуун даргатай Уртнасан төлөөлөгчтэй группийн штаб гэж байсан. 1948 оны 03 дугаар сард энэ нутгийн иргэн Цэрэндорж гэдэг айл Цагаан хоргост гэдэг буудалд байсан дал гаруй морьтой хасаг ирэхэд Цэрэндорж буудалцаад тэр хүнийг буудаж хороогоод тэмээ малыг нь хөөгөөд явах гэж байтал нь бид отрядад мэдэгдээд отрядын цэрэг машинтай, бид нар морьтой очоод буудалцаад 2 Хасгийг хороож хөөцөлдөөд явтал хил давж зугтсан. Тэр үед малчид тархай бутархай зэлүүд газар байсан учраас хэл авахад хугацаа алддаг байсан. 1947 оны баруун хилийн тулгаралтын дараа 1948-1985 онуудад хилийн Гурван хүүхэд, Байтаг, Ярант, Олон булаг, Зээг, Улаан хад гээд хилийн заставууд байгуулагдсан.

1947 оны 11 дүгээр сарын үед Хөх толгойн 6 дугаар отрядын дэргэдэх 5 дугаар тасаг гэж тусгай анги байсан Тусгай ангийн даргаар ахмад Зодов, ахмад Балдандорж нар ирж группийн гишүүдэд үүрэг өгч ахлагч Зоноров, Хоовоо, Шилэг, Намсрай, Манж нарыг Хил дээрээс цааш явуулаад үүрэг биелүүлээд ирэхээр

биднийг тосож авдаг байсан. Бид нар тагнуулд явахдаа Шинжааны зүгт 3 удаа, урагшаа Бар хөл Мичингийн уул чиглэлд 2 удаа нийт 5 удаа явсан явахдаа өгсөн үүргийг сайн биелүүлсэн байна гэсэн дүгнэлт авч байсан 2 удаад нь амьд хэл барьж байлаа. Группийн шугамаар улс эх оронд зохих үүрэг гүйцэтгэж ирсэн. 1948 оны 05 дугаар сараас Баруун хил хязгаар нутаг ард түмэн маань амар амгалан сайхан амьдарцгаадаг болсон.

Ахмад дайчин Б.Шийлэгийн гавьяа шагнал, Хязгаарын цэргийн ойн медалиуд, Байтагийн тулгаралтын ойн медалиуд, Цэргийн гавьяаны одон, Байлдааны гавьяаны улаан тугийн одон хоёр, Тусгаар тогтнолын одон, Бусад одон медалиуд.

/Бямбын Шилэг өөрийн дурсамж.2023 оны 2 дугаар сарын 6-ны өдөр/

Ванчинсүрэнгийн Гомбо



Ванчинсүрэнгийн Гомбо /жав/ 1915 онд Засагт хан аймгийн Ёст бэйсийн хошууны нутаг “Дунд голын ам” хэмээх газар малчин ард Ванчинсүрэнгийн 3 дахь хүү болон мэндэлсэн. 1938 онд ардын цэрэгт татагдаж Завхан аймаг дахь 32 дугаар морьт хороонд түгээгч хийж байхад дорнод хил дээр хар дайн эхэлжээ. Мянга мянган аавын хөвгүүд хийлийн зүг, галын шугам руу хөдлөв. Монгол улсынхаа дархан хилийн зүүн, баруун хязгаарт буун дуун гаргаж явсан, хал үзсэн ахмад дайчин В.Гомбын тулалдааны жилүүдийн түүхэн дурсамжаас сөхөж үзье. Нэг мянга есөн зуун дөчин нэгэн он гарч Монголын баруун хязгаарт байлдааны цагийн байдал ширүүсэж, Халхын голын анги

нэгтгэлүүдийн туршлагатай дайчдаас сонгон авч томилон шилжүүлж байжээ. Хасгийн зэвсэгт дээрэмчид олноороо удаа дараа уулгалан дайрч, ард иргэдийг хөнөөн, мал хөрөнгийг нь дээрэмдэж байсан цөвүүн цаг л даа. Энэ үед Морьт сумангийн туршлагатай дайчин В.Гомбо дайчин нөхдийнхөө хамт Алтайн хөх уулсын цаад хормойд хасгийн дээрэмчидтэй тулж эхлэв. Хасгууд мориндоо ч гарамгай, гайхалтай цэцэн буудна. Винтовын жаданд малгайгаа өлгөөд хадны дээгүүр цухуйлгаад буулгахад л хоёроос гурван ч сум орчихсон байх жишээтэй. Голдуу тайрсан карабинаар зэвсэглэсэн тэдний арьсан өмсгөл нь уулын хад асгаас ялгахад тун бэрх. Хасгуудын нэг томоохон ур чадвар нь 41 чулуугаар ховлог татан мэргэлдэг байсан явдал юм. Тэд ховлог гүйлгээд л болзошгүй аюулаас өөрсдийгөө олон ч удаа аварч байсан түүхтэй гэдэг. Монголын хувьсгалт цэргүүд Хавтаг, Байтагийн орчим дээрэмчдийн нэг томоохон бүлгийг бүрэн бүслээд гал нээх даргын тушаал хүлээн тэднийг сэм ажиж байлаа. Тас харанхуйд задгай түүдгийн дэргэд сууж байсан хасаг эр 41 чулуугаараа мэргэлээд гэнэт орилон босож ах дүү нар минь дайснууд биднийг бүсэлчихсэн байна. Амьд гарах найдлага алга хэмээн, уурсандаа цай даргилуулж байсан тогоогоо өшиглөхөд манайхан тал талаас нь нэгэн зэрэг гал нээн устгажээ. Бор цонж, Хавтаг Байтагийн орчмоор бүгсэн хасгийн бүлгүүдийг нисгэгчид хайр найргүй бөмбөгдөж байсан ч дээрэмчид галын цэгээ байнга өөрчилж, монголчуудын эсрэг бүл цөөтэй ч их авхаалж самбаатай, эрэлхэг тулалдаж байсныг цагтаа Монголын хувьсгалт цэргийн дарга нар ч хүлээн зөвшөөрч байжээ.

/81-р суваг сонин 1997 оны арван нэгдүгээр сар №007/.

Дуучин ахмад Гочоогийн Гэлэгжамц

Дуучин ахмад Гочоогийн Гэлэгжамц Архангай аймгийн Их тамир сумын нутаг, “Хөх даваа” хэмээх шазар 1925 оны 10 дугаар сарын 20-нд малчин Гочоогийн 6 дахь хүү болон мэндэлсэн.

1936 онд сумын зуны сургуульд ажил суралцаж, анхан шатны боловсролтой болж, 1942-1946 онд УБ хот дахь харилцаа холбооны техник кумд орж, телефон харилцааны дунд мэргэжлийн техникч, 1961-1965 онд Зөвлөлт холбоот Улсын Улан-Удэ хотын Дорнод Сибирийн Улсын соёл урлагийн дээд сургуулийг Найрал дууны багш, удирдаач мэргэжлээр төгссөн.

1945-1963 он хүртэл Хязгаарын цэргийн дуу таньцын ансамбльд ахлагч дуучин;

1953-1961 онуудад Ардын армийн дуу бүжгийн ансамбльд дуучин, гоцлол дуучнаар, хилийн цэргийн болон армийн ансамбльд тасралтгүй 18 жил цэргийн алба хаасан.

Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасны учир байлдааны гавьяаны одонгоор 2 удаа, цэргийн байлдааны медаль, “Атарчдын алдар” медаль, мөн Жуковын 100 жилийн болон ардын хувьсгалын 50, 60, 70, 80 жилийн медалиудаар шагнагдсаны дээр огц хилчин, соёлын болон боловсролын тэргүүний ажилтан зэрэг цол тэмдгээр шагнагдсан.

Хил хамгаалах өндөр хариуцлагатай үүрэгт, удирдлагын тушаал зааврыг биелүүлэхийн тулд уран бүтээлчид чармайн Хөх толгойн отрядын Хилийн бүх заставуудаар сар гаруй тэмээ, морь унаж, тоглолтын хувцсаа богцонд хийж, хөгжмөө үүрээд, эрэгтэйчүүд винтовоо мөрлөөд, 1948 оны 5 дугаар сарын эцсээр говийн аагим халуун наранд шарагдаж, 18-25 км замыг туулж, заставдаа очиж, хилчин дайчдадаа зонцерт тоглож байсан.

1948 оны 6 дугаар сарын 1-ний шөнө отрядад ирж хоносон. Гэтэл үүрээр түгшүүрийн дохио өгсөн. Отрядын штаб дээр бүх хүмүүс цугларч, отрядын дарга, дэд хурандаа Зоноров цугласан хүмүүст хандаж, манай отрядын хариуцсан хэсэгт Булган сумын нутгаар улсын хилийг зөрчсөн иргэдийг саатуулах арга хэмжээ авахад гар бие оролцсон билээ.

Дорлигжавын Цанжид

Дорлигжавын Цанжид 1925 онд Завхан аймгийн Ургамал суманд Дорлигжавын 2 дахь хүүхэд болон мэндэлсэн. Эцэг эхийн гар дээр өсөн хүмүүжиж мал маллаж байгаад 1945 онд Хатгалын ноос угаах үйлдвэрт ажиллаж байхдаа Зөвлөлтийн улаан армид явуулах эсгий гутлыг өдөр шөнөгүй шамдан хийж байсан.

Дорлигжавын Цанжид нь 1947 онд ардын цэргийн албанд мордож баруун хязгаарын Бодончийн 6 дугаар отрядад алба хааж, 1947-1951 онуудад байлдагч, бага дарга, бага дэслэгчээр цэргийн алба хаасан.

Гоминданы болон хасгийн дээрэмчдээс удаа дараа хил зөрчсөн байлдаан, мөргөлдөөн болдог хүнд үед хилийн цэргийн нөхдийн хамт удаа дараа байлдаанд орж дайсантай тулалдаж байсан билээ. 1950 оны 10 дугаар сарын 17 хүртэл байлдагч, бага дарга байгаад 1950 оны 10 дугаар сарын 17-нд дэвшиж бага дэслэгч болж Баянмодны заставын даргаар дэвшиж ажилласан юм. Хичээл сургуульд сайн суралцаж, байлдаанд сайн оролцож, хил хамгаалалтыг сайн хамгаалсан гэж 1948 оны 09 дүгээр сард БНМАУ-ын онц хилчин цол тэмдгээр шагнуулж байлаа.

Гавьяа шагналууд:

“Байлдааны гавьяаны улаан тугийн одон”, “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, “Алтангадас одон”-гоор 3 удаа, “Засгийн газрын жуух”, “Жуковын медал”, “Зэвсэгт хүчний 40, 50, 60, 70 жилийн ойн медаль”, “БНМАУ-ын Онц хилчин”, “БНМАУ-ын тэргүүний барилгачин”, “Соёлын яамны жуух”, “Барилгын яамны жуух”

Сонгуульт ажил:

“Завхан аймгийн Завханмандал сумын депутат”, “Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн депутат”, Хэнтий аймгийн Өндөрхаан хотын депутат”-аар тус тус сонгуульт ажилд ажиллаж байсан.



Раашийн Хээмчиг

Би 1947 оны хавар 5 дугаар сард 21 настайдаа цэргийн албанд татагдан Ховд аймгийн төвд байрлаж байсан Ардын цэргийн 25 дугаар морьт хороонд анх хуваарилагдан алба хааж эхэлсэн. Намайг цэргийн алба хаах үед улсын баруун хил түгшүүртэй, Гоминданы цэрэг, Оспаны дээрэмчид байнга нутаг орон луу өндөлзөж, өнгийсөн хэцүү цаг үе байсан юм. Ховд, Баян-Өлгий, Увс гээд 3 аймгийн шинэ цэрэг залуус цугларан ирж карантинд байсан. Тэр үед 40 Хоногийн карантин байх ёстой гэж ярьдаг байсан цаг үеийн түгшүүртэй байдлаас болоод тийм олон хоног

болоогүй, би сар хүрэхгүй хугацаанд л байсан. Шинэ цэргүүд бид нарын хөдөөгийн малчин ардын хүүхдүүд байсан, би цэрэгт ирэхээсээ өмнө гэрээр бичиг заалгаж муухан уншдаг, 4 аргын тоо боддог болсон байлаа. Энэ карантинд байх хугацаанд надад тусгайлан миномёт гэдэг буугаар буудахыг салаан дарга Сахьяа тусгайлан зааж сургасан. Энэ бууг 1818 онд Украин улсад үйлдвэрлэгдсэн гэж бидэнд таниулаад уг буугаар буудах арга, тэсрэх бодис хийж цэнэглэх, хараа тохируулах гээд л зааж сургаж байлаа. Нэг буун дээр жинхэнэ, туслах гэсэн 2 наводчинг, сум зөөгч, сум угсрагч гээд 10 хун ажилладаг, би жинхэнэ наводчик буудагч нь болсон. Хоёр орос сургагч байсан, тэд нар мөн салаан дарга бууны хараа зайг нь тохируулсныг нь шалгаж "ХОРОШОО ОГОНЬ" гэхээр нь бууддаг байлаа. Ингэж биднийг сургасан Нэг өдөр ГАЗ-51 машин ирээд бууг ачаад Уушигийн застав дээр биднийг авч ирээд орхисон, тэнд хэд хоноод, түүнээсээ цэрэг бид нар өөрсдөө явган маршаар буугаа салгаж хэсэг хэсгээр үүрээд Байтагийн Хужиртад ирлээ, тэр үед 7 сар байсан шиг билээ. Зайсановын онгоц дайсан луу бөмбөгдөх ажиллагааны үеэр бид буугаараа уг объект руу мөн л буудалцаж тэнд сар гаруй болсон. Онц буудагч болж байлаа.

Би ардын цэргийн ангид 1 жил 8 сар алба хаах хугацаанд 1948 оны 6 сард байхаа Мэргэний ууланд Оспаны дээрэмчидтэй манай дайчид тулалдаад Оспаны 22 баатрыг бут цохиж явах үед, би холбоочны үүрэг гүйцэтгэсэн юм. Ангийн дарга

Рэнцэн, штабын дарга Цэрэндорж нарын тушаалаар Ардын группийн тусгай ангийн төлөөлөгч. Гэрэлчулуунд байлдааны үеийн нууц бичгийг өөрийн биеэр хүргэн өгч цэргийн үүргээ нэр төртэй сайн биелүүлсэн.

Ус маш их. Туулж гарахад хэцүү байсан ч намайг орон нутгаа сайн мэддэг, усанд сайн гэх сонгож тушаал биелүүлэх үүрэг өгсөн юм. Би ус руу орохдоо нутгийн Цагаадай гэдэг хүнээс гаталга асууж арай дөнгүүр нь ус таван салаа болж урсаж байгаа хэсгээр нь гаталсан юм. Булган гол угаасаа үерлэхээрээ бүр сүртэй их үер болдог юм. Би хувцсаа тайлж бичиг, бууны замгаа авч гутлынхаа хоншоорт хийж түрүүг нь сураар боож ус орохоос хамгаалаад хувцас буугаа ганзагалаад, ус ирж байгаа талын дөрөөгөө уртасгаад, эсрэг дөрөөгөө богиносгоод, ингээд л морьтойгоо ус руу ороод явчихлаа, морины толгой, дэл нь харагдаад, ус миний суга даваад, аюултай дээрэм, тонуул болж байсан үе байлаа.

1948 оны зун Халзангийн хөтөл гэдэг газар байлдагч Ханджав, Тогторхаан бид гурав хилийн манаад гарч байхдаа хил давсан хоёр этгээдийг илрүүлэн баривчилж улмаар Баян-Өлгийн Туулайтын заставд хүргэж хүлээлгэн осон учир тусгай шагналаар шагнагдаж билээ.

Цэргийн алба хаах сүүлийн 2 жилийн хугацаанд би Хилийн цэргийн Байтагийн 13 дугаар заставд шилжин цэргийн албаа үргэлжлүүлэн хааж 1950оны 9 сард халагдсан юм.

Байтагийн 13 дугаар заставыг Дандар баатрын нэрэмжит гэдэг байсан. заставын дарга маань Дамдинсүрэн гэж хүн байж билээ. 13 дугаар застанд 2 жил гаруй болох хугацаанд Оспаны дээрэмчид манай эх орон, нутаг орон луу маань байнга онголзон дайрч байсан үе юм. Би хилийн манааг ахалж постод гарч эх орноо хамгаалах үүргээ гүйцэтгэж байлаа. 1948 оны 8 дүгээр сар байхаа намайг тус заставд албаа хааж хилийн манаанд гардаг байх үед дарга нар маань үүрэг биелүүлж яваад амь эрсэдсэн юм. Тусгай даалгавар гүйцэтгэхээр 10 цэргийн хамт заставын дарга Дамдинсүрэн, тасгийн дарга Дамба нар дайсны гүнд нэвтэрч баатарлагаар тулалдан амь насаа алдсан боловч дайсанд багагүй хохирол учруулж гавьяа байгуулсан. Тэр үед уг тулалдаан болсон газар Равдан генерал очсон юм. Малын эмч, хүний эмч 30 цэргийн хамтаар очиж шалган, амь үрэгдсэн хоёр хүнийхээ цогцсыг авч хүний ёсоор Бүдүүн Харгайтын аманд оршуулахад би

оролцож, хожим 80-оод онд тэдний шарилыг цэргийн газрын холбогдох хүмүүст тодруулж зааж өгсөн. Тэд эх орныхоо төлөө явж байгаад амь үрэгдсэн үнэнч хөвгүүд нь байлаа. Би анх 5 жилийн цэргийн албанд татагдсан боловч 1950 оны 9 дүгээр сард 3 жил 4 сар алба хаагаад халагдсан. Энэ үед Оспаны дээрэмчид дарагдаж хил тай болж байлаа. Сүхбаатар жанжны гэргий Янжмаагийн санаачилгаар цэргийн албыг 3 жил болгох шийдвэр Засгийн газар гаргасан гэж яригдсан, цэргүүд бид нар ч ямар сайхан ээж бэ гэлцэн баярлаж халагдаж билээ. Би цэргийн албанаас халагдаж ирээд нутагтаа Ховд аймгийн Булган сумын Жаргалын зам нэгдлийн Байтаг багт мал, маллан хөдөлмөрлөж амьдрахдаа 33 жил хилийн 87, 88, 89 дүгээр баганыг хариуцан, долоо хоногт нэг удаа хил орчмоо шалгах үүрэг гүйцэтгэдэг Хилийн группийн гишүүн байж эх орныхоо торгон хилийг манан хамгаалах үүргээ насан туршдаа гүйцэтгэсэн. 1971 оны хавар хил давсан хоёр этгээдийг Байтагийн заставд мэдээлж, хил зөрчигчдийг баривчилж байсан.

Эр цэрэг хүн эх орныхоо төлөө үүргээ гүйцэтгэж байхдаа нэг хором ч цуцах, ядрахыг умартан эр биеэ үл хайрлан тэмцдэг юм. Дайчин нөхөд минь энэ үүргээ нэр төртэй биелүүлсэн гавьяатай эр цэрэг, эх орны үнэнч хүүхдүүд нь байсан.

Дурсамж

МАХН-ын ахмад гишүүн, залуучуудын ууган ахмад ажилтан

Б.Сейлханы хөдөлмөр, амьдралын замналаас

Бүрkitбайн Сейлхан 1928 онд төрсөн. 1942 онд МХЗЭ, 1950 онд МАХН-ын гишүүнээр элссэн.

Б.Сейлхан 1940 оны өндөр шаардлагын үед МХЗЭ-ээр хүмүүсийн нам, улсын үйл хэрэгт хүчин зүтгэж залуучуудын байгууллагаас эхлэн цэрэгжүүлсэн харилцаа холбоо, ус цаг уурын албанд он удаан жил үр бүтээлтэй, идэвх зүтгэлтэй ажиллаж нам, улсын үүрэг даалгаврыг насан туршдаа биелүүлж ирсэн ахмад үеийнхний төлөөлөгчдийн нэгэн болно.

Хөдөлмөр, амьдралын замналаас зарим зүйлийг тодорхой дурдвал:

Б.Сейлхан Баян-Өлгий аймаг байгуулагдсан анхны жилүүдээс эхлэн Эх орныхоо Социалист бүтээн байгуулалтад гар биеэр оролцож дэлхийн II дайн, 1945 оны чөлөөлөх дайн, 1944-1948 онуудад болсон баруун хилийн зэвсэгт тулгаралтын үед партизан, отрядад туслах группийн нууц албанд тусгай үүрэг, даалгавар биелүүлж явснаа дайны хүнд жилүүдэд МХЗЭ-ийн ажилтны хувьд ялалтын төлөө бүхнийг фронтод “Бүхнийг ялалтад” гэж залуучуудын хүчийг зохион байгуулан дайны үеийн нам, төрийн уриа, бодлогыг хэрэгжүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн болно.

1950-аад оны үед тэр үеийн нам засгийн бодлого нэгдэлжих хөдөлгөөнд ард иргэдийг хамааруулах, хамтран амьдрахын давуу талыг сурталчлах, хүн амыг боловсролтой болгох, улс, эх орноо хөгжүүлэх шаардлагыг тайлбарлан таниулах ажилд идэвх зүтгэл гарган ажиллажээ.

Дэлхийн II дайн 1945 оны чөлөөлөх дайн, 1950-1960-аад онуудад үргэлжилсэн Солонгос, Вьетнамын эрх чөлөөний дайны үед тусламж цуглуулах бүх нийтийн хөдөлгөөнд Залуучуудыг өргөн хамааруулж, мөн дайны шударга үнэн мөнийг олон түмэнд тайлбарлах, улсын баруун хилийн зэвсэгт тулгаралтын үед тагнуул тусгай үүрэг, даалгавар биелүүлж, удаа дараа хилээс нууц мэдээ дамжуулан хилчдэдээ унаа хоол, хүнс хүргэх ажилд биеэр оролцож дайны цагийн хатуу үүргийг биелүүлэн нам, эвлэлийнхээ үүрэг даалгаврыг биелүүлж байжээ.

Б.Сейлхан нь тус аймагт ус, цаг уурын албаны тулгийн чулууг тавилцаж 32 жил тогтвор суурьшилтай ажиллаж, энэ байгууллагыг бэхжүүлэн, боловсон хүчнүүдийг халамжлан сурган хүмүүжүүлэх, материаллаг баазыг бэхжүүлэхэд өөрийн ухамсарт амьдралаа зориулан ажилласан ахмад цаг уурч.

Нийгмийн гишүүн, иргэн хүний идэвхтэй байр сууринаас эрхэлсэн ажлын зэрэгцээ засаг-захиргааны сонгуульт ажлыг олон жил, нэр төртэй хийж Өлгий хотын ОСГ-ны хорооны даргаар 20 гаруй жил сонгогдож, олон түмний итгэл найдварыг хүлээж орон нутгийн хурлыг сонгох 8, 10, 11, 12, 13, 14 дэх удаагийн сонгуулиар депутатаар сонгогдон ажиллаж ирсэн нь улс төр, нийгмийн идэвх, хөдөлмөрийн баталгаа юм.

Мөн “Байлдаанд оролцсон ахмад дайчин”, “Ахмадын алдар”, “Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэг”, “Монгол улсын цаг уурын тэргүүний ажилтан” цол,

тэмдгээр залуучуудын байгууллагын хүндэт медаль, хүндэт жуухаар тус тус шагнагджээ.

-МАХН-ын ахмад гишүүн Б.Сейлхан улс нийгэмдээ гаруй жил үнэнч шударга, идэвх зүтгэлтэй хөдөлмөрлөн залуу үеийнхнийг ахмадын яруу алдарт дайчин замналаар хүмүүжүүлэхэд өөрийн авьяас билэг хүчин чадлаас дайчлан ажиллаж ирсэн манай ахмад үеийнхний төлөөлөгчдийн нэгэн болон учраас хөдөлмөр, амьдралын замналаас тодорхойлов.



Хандын Намсрай: 1927 онд Хөвсгөл аймгийн

Тосонцэнгэл сумын нутагт малчин ард, Хандын ууган хүү болон мэндэлсэн. Бага насаа эцэг эхийн гар дээр мал маллаж өссөн.12 насандаа сумын улаан гэрээр бичиг үсэг сурч байсан.1943 оны намар Улаанбаатар хотод ирж, Өргөн чөлөөнд байрлах, ХАА-н техникумд элсэн ирж 3 жил суралцан, малын бага эмчийн мэргэжил эзэмшсэн. Сургуулиа төгсөөд нутагтаа очиж 1 жил орчим сумын мал эмнэлэгт ажиллаж байгаад 1947

онд цэргийн албанд татагдсан.

Эхлээд Хилийн цэргийн “Тээврийн рот”-ын жолооны сургуульд орж суралцсан. Жолооны сургууль төгсөхөөс өмнөхөн 1943 оны хавар тэр үед хурандаа цолтой байсан Цэдэн-Иш генерал Архангай аймгийн харьяат Гуунаа бид хоёрт жолооны үнэмлэхийг минь шалгалтгүйгээр өгч, Баруун хилийн тулгаралт болж байсан Ховд аймаг руу зэвсэг техник хүргэх цуваанд явуулсан юм. Цувааг ахмад Цэнд гэх хүн ахалж 20 гаруй хүн ЗИС-5 машинтай явсан. Ховдод очиход дэслэгч Зундуй гуай зэвсэг техникийг (бөмбөг, сум) хүлээн авч, Гуунаа бид хоёрт тус бүр 60 сумтай винтов буу өгсөн ба бид хоёр Ховдын Булганы 5-р отрядад тулгаралт бүрэн дууссаны дараа 1949 оны сүүл хүртэл алба хаасан. Харин зэвсэг хүргэсэн бусад ахлагч цолтой жолооч нар зэвсгээ хүлээлгэн өгөөд буцсан.

Тэр үед Гоминданы зэвсэгт дээрэмчид бараг өдөр бүр хил зөрчин орж ирж, дээрэм тонуул хийж байсан тул бид хилийн застав, галын шугам руу зэвсэг техник

хүргэхээс гадна дайсны байгаа газарт цэрэг дайчдыг зөөж, тэдэнтэй хамт зэвсэг барин тулалдах тохиолдол ч гарч байсан. Зам гэхээр юм байхгүй, маш их бартаатай газраар явдаг байснаа санаж байна. Нэг удаа мэдээ аван салаа цэрэг ачин, дайсны байрлаж байсан газарт очиход 7 хасаг дээрэмчидтэй халз таарч, тулалдсан ба тэднийг уул руу зугтаахад араас нь нэхэн хөөж байхад морь нь тахтай байсан болов уу гэсээр оч манарч харагдаж байсан. Тагнуулд явсан дэслэгч Зундуй гуайг хил орчим тосож авах даалгавар аваад очиход 2 цэргийн хамт их яварсан байдалтай байсан. Булган сумаас баруун урд зүгт байрлаж байсан нисгэгч Зайсанов гуайд бөмбөг сум хэрэгслийг нь байнга хүргэж өгдөг байсан. Харлаг тайлгийн ууланд үүрлэчихсэн байсан дайснуудыг дээрэмдсэн малтай нь хамт бөмбөгдчихсэн, үнэр танар болчихсон байсныг нүдээрээ үзсэн. Би Булганы Үенч, Буданчийн, Нарийн Яргайтын болон Мэргэний, Дайчигийн заставууд руу их явдаг байсан. Харин төвд отрядад байхдаа Баян-Өлгий аймгийн Цагааннуур сум руу 2 удаа цэргийн хоол, хүнсний хангалт хүргэж байсан. Мөн заставуудын барилга барихад хэрэглэх чулуу зөөх гэх мэт дарга захирагч нарийн өгсөн үүрэг даалгавар, тушаал бүрийг биелүүлж ирсэн. Ховдоос 1949 оны сүүлээр буцаж ирээд тээврийн ротод албаа үргэлжлүүлж хаасан. Манай ротын захирагч анх намайг очиход дэд хурандаа Бөө, дараа нь ахмад Санжаа нар байсан.

Тусгай хамгаалах хорооны захирагчийн жолоочоор албаа хааж байгаад 1950 онд цэргээс халагдаж, нутагтаа очиж 2 сар амраад мөн оны сүүлээр Улаанбаатар хотод шилжин ирсэн. Анх 1950 оны намар төв театрт жолоочоор орж ажилласан. Тэр үед театрын даргаар Нямын Цэгмэд гуай ажиллаж байсан. 1956 онд барилгын 1 дүгээр баазад 10 шинэ машин ирсний нэгийг авч жолоочоор, 1956 оны сүүлээр үнэн сонины газрын даргын жолоочоор 1 жил ажиллаж, фото сурвалжлагчаар 4 жил тус тус ажиллаж байгаад 1964 оноос намын төв хорооны намын ажлын хэлтсийн харьяа Монголын эмэгтэйчүүдийн орооны Монголын эмэгтэйчүүд сэтгүүлд сурвалжлагчаар ажилласан. 1949 оноо тээврийн 1 дүгээр баазад ачаа тээврийн жолоочоор ажиллаж байгаад, 1987 онд өндөр насны тэтгэвэртээ гарсан. 1962 онд Монгол ардын хувьсгалт намын гишүүнээр элссэн.

Гавьяа шагнал: ардын хувьсгалын 70 жилийн ойн медаль, VI, VII таван жилийн гавшгайч тэмдгээр тус тус шагнагдаж байсан. Ямар нэгэн ял шийтгэл эдэлж байгаагүй. 2001 онд Баянгол дүүргийн хүндэт иргэн болсон. 2011 онд Батлан хамгаалах яамнаас ахмад дайны үнэмлэх хүлээн авсан. 2018 онд цэргийн гавьяаны улаан тугийн одон, Монгол |Ардын намын 90, 100 жилийн ойн медальтай.

БАТЧУЛУУНЫ ЯДАМСҮРЭН

Батчулууны Ядамсүрэн нь 1927 онд Булган аймгийн Хутаг өндөр суманд төрсөн. Эцэг эхийн гар дээр мал маллаж өссөн. 1947 онд цэргийн алба татагджээ: Сүхбаатар аймгийн Эрдэнэцагааны отрядад 5 жил алба хаагаад, Баруун хилийн аймаг түгшүүртэй болоход тус отрядаас 20 гаруй цэргийн алба хаагчийг Ховын Булган сум дахь хилийн отрядад хүргэж байсан.



Чимэдийн Дорлигжав 1926.06.28-д Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын Хүрэн хошуу гэдэг газар төрсөн. Багадаа 2 настайдаа ээжээсээ өнчирч, хөгшин ээж болон аав эгчийн хамт мал маллан амьдарч байгаад 1948 онд цэрэгт татагдан Ховдын Булган сумд 24-р отряд, 3-р суман, 13-р заставд цэргийн алба 3 жил хаасан. 1950 онд цэргээс халагдаад нутагтаа ирж 1951 онд гэр бүлтэй болоод Завханы Яруу сумд түүхий түүхий эдийн эрхлэгчээр ажиллаж байсан. Улмаар 1980 онд УБ хотод шилжин ирж ганданд харуул хийн завсраар нь бурхны номд шамдан суралцаад лам болоод 1990 онд нутагтаа буцаж очин Цэцэн-Уул болон Эрдэнэхайрхан сумдад хийд барилцан шавилан сууж хамба лам байсан. 2007 онд том охиноо нас барах үед буцаж УБ хотод нүүж ирээд одоог хүртэл үр хүүхдүүдийнхээ асрамжид амьдарч байна.

Цэргээс ирээд 500 хонь авч авч маллаад, малчин болсон. Бас багийн дарга, клубийн эрхлэгч зэрэг хийж 2 удаа хөдөлмөрийн гавшгайч, ЗГ хүндэт жуух бичгээр

шагнагдаж байсан. Том гавьяа шагнал байхгүй. Дайнд оролцон болоод сум орон нутгаас урамшуулж шагнасан одон медаль нэлээд бий.

БУЯНХИШИГИЙН ЧОЙЖИЛЖАВЫН ДУРСАМЖ

Буянхишигийн Чойжилжав нь 1914 онд Говь-Алтай аймгийн Баян-Уул суманд төрсөн. 1935-1938 онд Байлдааны гавьяаны Улаан тугийн одонт тусгай хороо ба 5 дугаар отрядад цэрэг бага дарга, 1938-1942 онд 5 дугаар отрядад хилийн заставын дарга, 1942-1945 онд 23 дугаар отрядад хилийн сумангийн дарга, 1945-1947 онд 5 дугаар отрядад хилийн сумангийн дарга, 1948 онд 6 дугаар отрядад Байтаг богдод хилийн сумангийн дарга, 1951 онд 17-р отрядад хилийн сумангийн дарга, Байтаг 1951 онд татан буугдсан учир 1951-1952 онд Налайх дахь хорих лагерьд уурхайн эрхлэгчээр ажиллаж байсан. Түүний хөдөлмөрийг үнэлж Байлдааны медаль, 25 жилийн ойн медалиар шагнажээ. 1951.03-1952.08 сар Улаанбаатар хот НАХЯ-нд сурган хүмүүжүүлэгч салаан дарга, 1952.08 сар-1953.01 сар Улаанбаатар хотод Эрүүл мэндийн яаманд Бактери шинжилгээний лабораторид мөнгөний нярав, 1954.01 сар - 1954.12 сар Улаанбаатар хотод Барилгын яамны Тээврийн баазад нормчин 1954.12 сар - 1955.09 сар Цэнхэр мандлын модны, уул уурхайн авто жолоочийн курст сонсогч, 1955,09 сар - 1962.05 сар Улаанбаатар хотод Барилгын яамны барилгын трестийн авто баазад жолооч, 1962 -1965.05 сар Говь-Алтай аймгийн Тайшир сумын МААМС-д жолооч, 1965.05 сараас Говь-Алтай аймгийн Гуулингийн тэжээлийн аж ахуйд жолоочоор тус тус ажиллаж байсан. 1945.08 сараас 10 сард Б.Чойжилжав нь сумангийнхаа бие бүрэлдэхүүний хамт Өвөр Монголын Шилийн гол аймгийн Зүүн үзэмчин, Хянган аймгийн Солон, Дөрвөд хошуудын нутаг дэвсгэрт орогнож байсан дайсагнагч оргодлуудыг баривчлах, давшилт эхлэхэд Өвөр Монголын иргэд тал бүр тийшээ зугтан, эмх замбараагүй болсон. Айл өрхийг хэвийн аж төрөхөд, шилжүүлэн, тайван байлдалд оруулсан. Өөрийн улсын нам төрийн бодлогыг сурталчилж,

ухуулан айл өрхийг эмхлэн цэгцлэх ажлыг даан авч үүрэг гүйцэтгэж байсан. 1945 оны Чөлөөлөх дайны үед Баянцагааны 23-р отряд Өвөр монголын зүүн үзэмчин Солонбарагын хошууны нутагт байлдааны үүрэг гүйцэтгэсэн. Энэ отрядаас тус бүр 200 орчим хүнтэй 2 салбар томилогдож хил давсан Б.Чойжилжав тэр үед 2-р сумангийн дарга байсан. Отрядын дарга Баатарсүрэнгийн удирдлага дор Соёлзын уулаар хил давж Солонбарагын нутагт орж явсан. Оргон зайлж зугтаж байгаа япончуудаас хятадын төмөр замын Учагоу станц, Солонбарагын төв Солон хотыг япончуудаас чөлөөлөх байлдааны үүрэг гүйцэтгэжээ. Хилийн 23-р отрядын салбарууд 1945 онд Японы офицер 3, бага дарга 11, цэрэг 67 бүгд 81 хүнийг баривчилж хуулийн байгууллагад шилжүүлэн өгчээ. 1945 оны 10 сарын эцсээр эх орондоо эргэн ирсэн бөгөөд сумангийн дарга Чойжилжавыг Өвөр Монголын нутаг дэвсгэр дээр байлдааны үүргээ сайн биелүүлсэн гэж БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор байлдааны хүндэт медалиар шагнажээ. 1945 оноос Оспан, гоминданд урваж, Оспаны дээрэмчид хил зөрчин баруун хязгаараар дайсагнаж байсныг таслан зогсоох зорилгоор хязгаарын цэргийн удирдлага шилдэг офицер, цэргүүдээ баруун хязгаар луу татахад Б.Чойжилжав Дорнодоос Ховд руу шилжиж 5-р отрядын Байтагийн сумангийн даргаар томилогджээ. Тэр үед эх орны баруун хил түгшүүртэй байлаа. 1937-1941 оны тодруулга 1937 онд Хятадын Шинжаан мужийн хил залгаа нутаг Эзэнгол ба Альшаа мужийн нутаг, Цахар ба Хятадын мужуудтай хил залгаа нутгаар тусгай үүрэг гүйцэтгэж хязгаарын цэргийн хүчийг гол чиглэлд төвлөрүүлэхэд ач холбогдолтой болов. 1938-1939 онуудад Хилийн цэрэг нь аж ахуй, зохион байгуулалтын хувьд батжиж Улсын өмнө зүгийн нутгийн хилийн 4676 км шугамыг хамгаалан улсынхаа хилийг хамгаалах үүргийг дагнан хариуцсан 20 отряд, 24 суман, 80 застав хүч хэрэгслээр хамгаалах болсон юм. 1939 онд Халх голын байлдаанд Японы империалистууд Монгол зөвлөлтийн армид бут цохиулсныхаа дараа зүүн хойд хятадад сая гаран хүнтэй Квантуны армийг бэлтгэж манай улсын эсрэг тагнан турших, өдөөн хатгах ажиллагааг улам идэвхжүүлж байсан үед хязгаарын цэргийг улам бэхжүүлж, улсын хил хамгаалалтын албыг хүч нэмэгдүүлэн батлуулах ажлыг үе шаттай авч байв. 1939 онд Ардын цэргийн 10 дугаар дивизийн 35, 28 дугаар тусгай морьт хороог хүлээн авч сумын хээрийн 9, Баянцагааны 23 дугаар отрядыг байгуулахаар

шийдвэрлэв. Баянцагааны 23 дугаар отрядын даргаар хурандаа Бандийн Гандал, комиссараар Төмөөгийн Жамъян, штабын даргаар Навагжав нарыг томилов. Нэг нутагт өсөж торнисон Навагжавын нөлөө орсон болох намайг Баянцагааны 23 дугаар отрядад мөн л тусгай үүрэг гүйцэтгэх тушаалтай зүүн хязгаарт ирэв. Тус отряд нь халхын цагаан уулнаас Нөмрөгийн голын эх хүртэл 300 гаран км хилийн хэсгийг хариуцдаг байв. Тусгай үүрэг гүйцэтгэж удаан хугацаагаар яваад ирэхэд эхнэрээ болгох гэж байсан Цагаан хэмээх бүсгүй маань нас барсан. Өнчин үлдсэн хүүхдийг маань тус отрядад цуг ажиллаж байсан Ориг гэдэг хүний эхнэр Буриад нь асран хамгаалж тэр айлд хүүхэд маань бүр дасчихсан ээж нь аав нь мэт болсон байсан учир намайг энэ хүүхдээ сайн санаат хүмүүст үрчлүүлээд Улаанбаатар хотод тусгай албанд мэргэших 3 сарын курст суралцахыг үүрэг болгосны дагуу ёсоор болгоод курс төгсөөд шөнө нь түргэн авч Ховдод дахин ирсэн юм. Тэрээр 1947 онд Байтаг нурууны олон удаагийн хилийн будилаанд оролцож мөн оны 4-р сард гоминданы хороо орчим цэрэг Байтаг богдын Хужиртын голд орж ирээд 2 сар орчим хуарагнаж байхад Б.Чойжилжавын сумангийн туслах Нэхий илрүүлж дээд удирдлагад илтгэжээ. Монгол улсын засгийн газраас БХЯ-ны байлдааны бэлтгэл газрын дарга хошууч генерал Б.Шагдаржавыг Байтаг нуруу руу томилон явуулж гоминданы цэргийг эх орноосоо хөөж гаргах ажлыг удирдуулжээ. 1945 оны 6 сарын 03-ны өдөр Б.Бадам, Б.Чулуундай нарыг явуулж Гоминданы цэргийн хороог манай нутгаас гарахыг тулган шаардсан бичиг хүргүүлэхэд гоминданыхан Бадамыг нь авч үлдэн тамлаж алсан. Харин Чулуундайг буцаан явуулж дарга нараасаа дагуулж ир гэж шаарджээ. Манайханд гоминданы талаас хариу өгөөгүй тул зэвсгийн хүчээр хөөж гаргахаар шийдвэрлэжээ.

1947 оны 6-р сард Байтаг орчимд болсон байлдааны тухай товч өгүүлье.

6-р сарын 3-ны өдрөөс ДЯЯ-ны сайд асан, Цэргийн яамны газрын дарга хошууч генерал Бат-Очирын Шагдаржавын командалсан Цэргийн яамны тусгай групп, Б.Чойжилжав даргатай хилийн суман, Хошууч генерал Матросын Зайсановын нисэх эскадрилтай хүч хавсран манай нутагт цөмрөн суурьшсан Гоминдан, Оспаны цэргүүдийг эх нутгаасаа хөөх ажиллагааг эхлэх гэж бэлтгэж байв. Байлдааны товлосон хугацаанаас 2 хоногийн дараа эхэлжээ. Дайсан: Тагнуулын

мэдээ, олзлогдсон этгээдийн мэдүүлгээр Гоминдан, Оспаны цэргийн хамтарсан хүчээр Байтаг орчмын газар нутгийг түрэмгийлэн эзэлж, тэндээ хориглон хамгаалж бэхжих зорилготой байв. Хилийн ойролцоо Оронбулагт Оспаны 300 орчим цэрэг байв. Тэд хөнгөн пулемёт, винтовоор зэвсэглэсэн. Хүн бүр 200 сумтай орос, япон винтовтой, гранат, сэлэмтэй. Хятад цэрэг энд 3-р сарын 27-нд ирж суурьшсан ба агт уналга, хоол хүнс сайтай байв. Хятад цэрэг 4-р сарын 10-нд ирсэн байна. Тэд Хужиртын эхэнд голлон байрлаж голын 2 талын толгой, хавцлуудаар окоп ухсан. Тэнд өдөрт 3-5, шөнө 5-10 хүн байнга харуулын үүрэг гүйцэтгэнэ. Өдөр бүр 15 морьтой хүн газар орны байдлыг явж тагнана. Байраа 2 хэсэг газраар 10-20 хүн үргэлж манана. Морьдоо уяж тэжээнэ. 5-р сарын 10-нд Цонжоос 97 тэмээгээр хуурай хэрэглэл авч ирсэн. Түрүү анги нь гол хүчнийхээ ирэх бэлтгэлийг хангаж байв. Хятадын 1000 гаруй цэрэг ирэх төлөв бэлтгэлтэй байв. Дайсан тулган шаардах бичиг аваад хориглолтод шургуу бэлтгэжээ. Манай хүч хэрэгсэл нь: (1947 оны 6-р сарын 5-ны байдлаар)

Гол хүч нь: Сэлэмт салаа 4, Суурьт пулемёт салаа 1, Миномётын салаа 3, Автоматын салаа 2, Танк эсэргүүцэх бууны тасаг 1, Ар тал хангалтын тасаг 1-тэй байв.

Бэлтгэл хүчинд: Сэлэмт салаа!, Автоматын салаа 1, Пулемёт салаа 1, Холбоо тасаг 1 байв. Генерал Б.Шагдаржавын мэдэлд: Д.Цэрэнжав даргатай тусгай батальон; М.Зайсановын нисэх эскадриль; 6 дугаар отрядын Б.Чойжилжав даргатай сумангийн хилчид, Пүрэвээ даргатай морьт тусгай суман байв. Байлдааныг 6-р сарын 5-ны өглөө М.Зайсановын нисэх эскадриль дайсныг бөмбөгдөн галын бэлтгэл хийснээр эхлэн Д.Цэрэнжавын батальон, Б.Чойжилжавын сумангийн морин ба явган цэрэг атаклан дайсныг бут цохих шийдвэртэй байв. Гэтэл Цэрэнжавын батальон шөнийн марш үйлдэхдээ төөрч Уушигаас Хужиртад биш, Нарийнхаргайт тийш явсан байв. Тогтоосон цагт Зайсановын онгоцнууд дайсны байрлалыг бөмбөгдөхөд аттакийн заагт зөвхөн Чойжилжавын суман байсан ба Цэрэнжавын батальон 10 км-ын хол зайтай, Шагдаржавын хээрийн командын байр 17 км-т Талынхар орчим байв. Дайсан нэг хэсэг сандарч, үймэлдээд учраа олж ашигтай байрлалыг эзлэн манайхныг тосон

байлдав. Дарга нар нь байлдааны өмнө цэргүүдээ тушаал өгөөгүй учир цэргүүд нь харсан зүгтээ шахам эмх замбараагүй буудаж, өөрсдийн санаачилгаар давшин байлдахад хүрэв. Байлдааны зохион байгуулалт, харилцан ажиллагаа хийгдээгүй тул аль салбар нь юу хийхээ ч мэдэхгүй, юу хийж байгаа нь ч мэдэгдэхгүй, радио холбоогүй зөвхөн бие холбоочноор холбоо барьж байв. Эх оронч дарга цэргүүд удирдлага, холбоогүй хэр нь өөрсдийн идэвх санаачилгаар бүтэн 12 цаг тасралтгүй байлдсан боловч ямар нэгэн мэдээ үүрэг авсангүй. Эмх замбараагүй болсон болсон байлдааны явцад Гоминданы цэрэгт туслахаар 18 цагт Оронбулагаас Оспаны 38 зэвсэгт дээрэмчид хүч нэмэгдүүлэн ирж фронтын нэг үзүүрийг ширүүн дайртал тэнд байсан удирдлагагүй дарга, цэргүүд аргагүй ухран зугтжээ. Дайсны идэвх илт сэргэж манайхныг бүх хүчээрээ бүслэхээр шийдвэрлэн ажиллав. Цагийн байдлын энэ мэдээг Шагдаржав хүлээж аваад гол хүчинд ухрах тушаал өгчээ. Тушаал авсан цэргүүд байлдааны талбарыг санд мэнд хаян морины хурдаар Хужиртын гол уруудан сандран гэдрэг зугтав. Гэтэл ухрах тушаал Б.Чойжилжавын хилийн суман болон хүнд пулемётын салаанд (Жонобазарын Жонабалханы) хүрсэнгүй. Хүнд пулемётын салаа ихээхэн хохирол хүлээж салааны дарга Ж.Жонабалхан (Баян-Өлгий), пулемётчин Жингийн Жономоо (Увс), Санжийн Дамдинсүрэн, Дамбын Готов, Равданы Пунцаг, Мягмарын Чимид, Лувсангийн Жаргал, Пүрэвийн Зодов, Занын Муухай нар амь үрэгдэв. Чойжилжавын суман дайсны бүслэлтийг сэтлэн шургуу байлдаж дайсанд багагүй хохирол учруулан хохиролгүй гарч ирэв. Харин тус сумангийн туслах Ж.Нэхийт, заставын дарга Сономын Санжаа, бага дарга Бандийн Баасанжав, цэрэг Хөхийн Даржаа, Дашдондог нар бүслэлтэд үлдэн бараг бүх сумаа буудаж, гранатаа дуусгаж, 2-3 удаа дахин дахин бүслэгдэж байж дайсны гүн тал руу гэтлэн гарч шөнөжин явж Нарийнхаргайтын эхээр даван нөхдөө олж очжээ. Шагдаржавын штаб Чойжилжавын суман, Нэхийтийн бүлгийг устсан гэж үзэж хохирлын тооцоонд оруулсан байлаа. Гэвч эрэлхэг хилчид нэг ч хүний гарзгүй, дайсанд багагүй хохирол учруулан бүслэлтээс гарчээ. Хилчдийн хоол хүнс муу, өвлийн хувцастай байсан хэдий ч амь өрссөн бэрхшээлийг сөрөн давж чадсан юм. Энэ өдрийн байлдаанд дээрх 9 хүн амь үрэгдэж, 10 хүн шархдаж, 3 хөнгөн пулемёт, 2 винтов түүний 21074 сум, 3 автомат, түүний 3480 сум, 1 радио станц, 1 ширхэг 12-14мм-

ийн танк эсэргүүцэх буу, 21 ширхэг 51мм-ийн мина, 2 морио олзлуулж, Шагдаржавтай холбоо барихаар буусан “ПО-1” онгоц эвдэрч, ихээхэн эд зүйл сүйджээ. Энэ тухай Монгол улсын баатар Ж.Нэхийт дурсан бичсэн нь:

“1947 оны гуравдугаар сард гоминданы морьт цэргийн хороо хүч манай улсын хилийг нэвтрэн Байтаг богдын Хужиртын голд ирж суурьшаад хилийн ойролцоо нутаглаж байсан энгийн номхон ард иргэдийг баривчлан алах, тэдний мал хөрөнгийг дээрэмдэх зэрэг бузар жигшүүрт ажиллагаа явуулж эхэлсэн үед Хужирт голд суурьшсан дайсныг бут цохих тушаал авч дайсны зүүн талаас гэнэт дайрах, агаараас онгоцоор бөмбөгдөх, агаар ба газрын дайралтыг огцом хийх тушаалтай, хошууч Цэрэнжав даргатай хороо, 50 орчим тэмээнд зэвсэг ачиж аваад 1947 оны зургаадугаар сарын 4-ний орой харанхуй болохын хамт Уушигаас гарч Нарийн Харгайтыг өгслөө. Газар бартаатай учраас ачаатай тэмээ хад хавцал, усанд боогдож, явж чадахгүй саатсанаас болж манай хороо давшиж эхлэх газартаа арай хүрч амжаагүй явтал манай онгоц яг цагтаа ирж дайсны хориглолт руу дайран бөмбөгдөж буудсан боловч дайсны хориглолт Хужиртын бартаат хад хавцлаар тарж биесээ далдлан ашигтай өндөрлөгүүдийг эзэлсэн учраас манай онгоц 20 шахам минут үргэлжлэн бөмбөгдөж буудсан боловч төдийлөн ашиг олж чадсангүй буцлаа. Манай хороо онгоцтой хамтран дайралт хийж чадсангүй, хожимдож дайсныг ашигтай өндөрлөгүүд эзэлсний дараа давшилтад орсон явдлаас дайсан ширүүн галтай тулгарч давшилт саатах аюул тулгарсан учир хорооны дарга хошууч Цэрэнжав намайг дуудаж тушаал өглөө. ‘Нөхөр ахмад та 35 цэрэгтэй, дайсны хориглолтыг сэтэлж ор! Таны орсон замаар манай хороо орж дайсанд цохилт өгнө’ гэв. Миний бие “тушаал гүйцэтгэе” гээд сумангийн дарга Чойжилжав, заставын дарга Санжаа, сумангийн төлөөлөгч Наандай, хөнгөн пулемётчин Тэгшээ, Дамдин, Сүхбаатар, Шагдар, Баасанжав нарын 35 хилчин авч гоминданыхны ашигтай өндөрлөг эзэлсэн хориглолт руу давшлаа. Дайсны төрөл бүрийн бууны, аадар борооны адил ширүүн галд манай салаа орж өндөрлөг өөд ахихад алхам бүр их үнээр олдохоор болсон боловч зоригтнууд үхлээс айхгүй, пулемёт, винтовын ээлжийн галаар дайсныг /толгой өндийлгөхгүй давшсаар хориглолтыг сэт дайрахад гоминданууд зугтлаа. Бид дайсныг дийлж байна гэж бодон улам ширүүн давшилтаа үргэлжлүүлсээр дайсны хориглолтын гүнд ортол

манай ар талын хүчнээс биднийг таслан авч бүсэллээ. Тэгээд зүг бүрээс галлалаа. Манай салаа арын хүчнээс хэтэрхий хол тасарч дайсны гүнд орж ирсэн нь ашиггүй болсон тул бүслэлтээс гарахаар шийдэж, арын сийрэг бүслэлтийн дундуур 70-80 метр зайтай газраар “уриа” хашхиран морины хурдаар дайран гарлаа. Дайсны групп бидний зүг байдаг чадлаараа галласан боловч манайхаас нэг ч хүн морь алж чадсангүй гарснаас үзэхэд Байтагийн уулыг л аргагүй онож байгаа байх, лав л бүхэл бүтэн морьтой хүнийг буудаад онодоггүй, дайсантай тулалдаж байна даа гэдгийг сайн ойлгож мэдлээ. Бүслэлтээс гармагц хэсэгхэн өндөрлөгт хүрч морь баригчдаар морио бариулж уулын бэлд орхиод тэр өндөрлөгийг эзлэн авч дайсны хагас дугуй бүслэлтэд орж байлдав. Гэтэл дайсны морьт цэргүүд баруунаас зүүн тийш Байтагийн уулыг нуруулдан 200-300-гаараа бидний ар талаар орж байгаа болов уу гэмээр явж далд орсоор байгаа харагдлаа. Энэ үед манай хороо дайсантай үргэлжлэн байлдаж байлаа. Гэтэл дайсны ар талын хүч бидний ар талаар ороон ирж, араас төрөл бүрийн буугаар гал нээж аянга цахилгаан бууж байгаа мэт уул хад нүргэлэн, манай салаа тэр өндөрлөгийн орой дээр дайсанд бүслэгдэж, зүг бүрээсээ галлуулж тогтох, хоргодох газаргүй болж, дайсны бууны сум ширүүн галласан учир морьд ширүүн мөндөр орж байгаа адил шороо босгон газрын хөрс хөдөлгөж эхэллээ. Манай салааны морьд руу бас ширүүн мөндөр бороонд зогсож байгаа адил чихээ хулмайлган, сүүлээ тас хавчиж, хөл дээрээ тогтохгүй бөмбөрөн чичирч байлаа. Манай салаа тэр өндөрлөг дээр тогтож чадахгүй болж ямар боловч дайсан руу дайран орж байлдахаар шийдэж, «мориндоо» гэж цэргүүдээ командлан, цэргүүд өндөрлөгөөс гүйлдэн бууж мориндоо хүрэх шахаж явтал дайсны миномёт, пулемёт, автомат бусад төрөл бүрийн буугаар манай салааг галлаж байгаад морин аттакаар орж ирлээ. Бууны пижигнэсэн дуу чимээ тэнгэр ниргэж байгаа юм шиг болж түүний дотор олон хүний «чак вай чак вай, мухмед мухмед» гэх мэт нарийн бүдүүн дуу чимээ, утаа манан болж, шороо тоос оволзон сүртэй бужигнаан болсон учраас би цэргээ удирдах боломж алдлаа. Би цэргүүдээ удирдах байтугай миний буудаж байгаа бууны дуу өөрт минь дуулдахгүй, дуу гарч байгаа эсэх нь мэдэгдэхгүй болж дайсны морин аттак ойртлоо. Би дэргэдээ явсан Санжаа, Данзан, Баасанжав, Дашдондог нарын 4 хилчдийг хэвт, аттак руу бууд гэж дохио өгч, хэвтүүлэн буудуулав. Бусад цэрэг

удирдлагагүй болж мориндоо мордон зүүн талын уул өөд морины хурдаар бужигнан явлаа. Бид тав уналга морьд үгүй өндөрлөгийн бэлд үлдэж дайсны морин аттак руу буудсаар П-1 гэдэг гранат хүн бүр дөрөвтэй явсан учраас түүнийгээ шидэхэд бэлтгэв. Аттакийн түрүүч зуугаад метрт ирэхийн хамт бид тав гранатаа цувуулан шидлээ. Бидний гранат дайсны морин аттак дунд тусаж лүн лан хийж оволзон утаа дээш цоргин тэсэрлээ. Дайсны морин аттак шигүү учраас голоосоо ярагдан хага зүсэгдэж утаа манан шороо тоосон дундаас том том бараан юм энд тэндгүй унаж үлдэж хоцорлоо. Амьд үлдсэн хэсэг нь бид тавын хоёр талаар дайран өнгөрөв. Явгарсан буюу шархадсан зарим хэсэг нь буцаж зугтаж эхлэв. Бид тав ийм бужигнаан дундуур гүйлдэн том том хар чулуутай хойшоо харсан цохио хад руу орж биеэ далдаллаа. Биднийг дайраад өнгөрсөн дайсны групп морьдоо далд хийгээд эргэж бид тавтай буудалцлаа. Нөгөө Хужиртын зүүн өндөрлөг өөд бужигнан явсан манай 30 цэрэг, дайсны хэсэг цэрэгтэй Хужирт голын зүүн өндөрлөг уулыг өрсөлдөн эзлэхээр морины хүч чадал үзэн давхив. Дайсны цэргүүд уулын хяр барин манай цэргийн урдуур тосож давхисаар уулын хярд байгаа ханан хадан дээгүүр гүйлдэн гарч ирлээ. Манай цэргүүд уул өөд өгсөн явсаар ханан хадны ёроолд тулж ханан хадны дээр доор хоёроос хэдэн минут буудалцав. Дайсан манай цэрэг рүү гранат хаяж байгаа нь аюултай байлаа. Харсаар байтал манайхны морьдоос 2 морь дайсны гранатад өртөж таслагдан унаж байгаа харагдлаа. Тэгээд төдийлөн удсангүй манайхан морьдоо авч унаад ханан хадны ёроолоор явж ханан хад шувтрахын хамт дайсан руу дайран орж уул хад шүргэлцэн «уриа» хашхиран, гранат тэсэлж, төрөл бүрийн бууны дуу нижигнэн ширүүн тулалдаан түр зуур болоод чимээгүй боллоо” гэжээ.¹ 1973 он Ийнхүү Чойжилжав дайсны ширүүн голын дундуур салаагаа чадамгай удирдан, зориг баатарлагийн үлгэр жишээг үзүүлэн дайсны хориглолтыг цөмрөн гарч цагаан бургасны гол руу нэвтэрч чаджээ. Хүнд хэцүү 1947 онд түүний удирдсан сумангийн хамгаалдаг хилийн хэсэгт 6 дугаар сарын 5-7 дугаар сарын 4 хүртэл том, жижиг 20 шахам удаа байлдаан болжээ. Тэдгээр амь өрсөн зэвсэгт тэмцэлд Чойжилжавын удирдсан суман, заставуудын хилчид хамгийн хүнд байлдааны үүргийг гүйцэтгэж хүний амь хохирол багатай ялалт байгуулж байжээ. Заримд нь биечлэн оролцож

¹ “Хилчид өгүүлж байна” номын 40-45-р тал.

эр зоригтой, байлдааны галын дунд салбарыг удирдан зохион байгуулах авьяас чадвараа тод томруун харуулсныг дээр өгүүлсэн билээ. Амьдралынхаа 17 жилийг улсын хилийн аль түшүүртэй хэсэгт шугамын застав, суман удирдаж, өдөр шөнөгүй дайсны заналхийллийн дор өнгөрүүлсэн тэр, гайхамшигтай хилчин офицерын тухай мөхөс би олдсон түүхэн баримтыг ашиглан товчхон дурдсан минь энэ.